



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2015 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 407

Улаанбаатар хот

Г Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зовшоорол, бүртгэлийн журам, заавар батлах тухай Г

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.2.3, 6.2.4, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3, 14 дүгээр зүйлийн 14.2.10, 14.2.13, 14.2.15, 15 дугаар зүйлийн 15.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 6 дугаар зүйлийн 6.2.4, 6.2.6, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зовшоорол, бүртгэлийн журам”-ыг 1 дүгээр хавсралтаар, “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар”-ыг 2 дугаар хавсралтаар, “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл, зөвшөөрөл, бүртгэлийн хүсэлт, баримт бичгийг хүлээн авах, хянах заавар”-ыг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тогтоолыг 2016 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

3. Энэ тогтоолыг мөрдөж эхэлсэн өдрөөс Хорооны 2007 оны 127 дугаар тогтоолоор батлагдсан “Гадаад улсад салбар, толоологчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын үйл ажиллагаа явуулах журам”, 2008 оны 61 дүгээр тогтоолоор батлагдсан “Ердийн даатгал, давхар даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам”, 2011 оны 302 дугаар тогтоолоор батлагдсан “Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох журам”, “Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдэд тавигдах шаардлага, тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт батлах тухай” Хорооны 2007 оны 173 дугаар тогтоол, “Гадаад улсад салбар, толоологчийн газраа нээх болон гадаадад үйл ажиллагаа явуулах даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага батлах тухай” 2008 оны 175 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Энэ тогтоолыг мөрдөж эхэлсэн өдрөөс Хорооны 2013 оны 198 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлтийг гадархайлох журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.4 дэх заалт, 3 дугаар зүйлийн 3.1.9-3.1.12, 3.2, 3.4-3.7, 3.9-3.10 дахь хэсэг, 1 дүгээр хавсралт, Хорооны 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд тавигдах шаардлага”-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дэх хэсэг, 2 дугаар зүйл, 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалт, 4 дүгээр зүйлийн 4.1.2 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5. Энэхүү тогтоолоор батлагдсан журам, зааврыг нэг мөр ойгож хэрэглэх, програм оруулах, турших, шалгах, мөрдүүлж хянан үзэх чиглэлээр ажиглагчид сургалт зохион байгуулах, сурталчлах, зов ойлуулах ажлын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлж ажиглахыг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/, Хяналт, ажиглалтын газар /Б.Оюунцацрал/, Даатгалын зохицуулалтын газар /Ц.Нацагдорж/, Бүртгэл, зөвшөөрлийн газар /Д.Мөнхбаяр/-г даалгасугай.


6. Журам, зааврын хэрэгжингэд хяналт тавьж, олон нийгэд мэдэгдэхийг Ажлын алба /Б.Батсэлэнгэ/-нд даалгасугай.

ДАРГА



З.НАРАМТУЯА

ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН ЖУРАМ



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Санхүүгийн зохицуулах хороо /цаашид “Хороо” гэх/-ноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, бүртгэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

1.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хүссэн өргөдөлд хавсаргаж ирүүлэх баримт бичигт тавигдах шаардлага, бүрдүүлэх, баримт бичгийг хүлээн авах, хянах зааврыг Хорооны тогтоолоор батална.

1.3. Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч дараах нийтлэг шаардлагуудыг хангаж ажиллана:

1.3.1. Аж ахуйн нэгжийн тусгай зөвшөөрлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

1.3.2. Хорооноос тогтоосон үйл ажиллагаанд тавигдах шаардлага, шалгуурыг хангаж ажиллах;

1.3.3. Хорооноос баталсан зохицуулалт үйлчилгээний хөлс төвлөрүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулсан журмын дагуу тогтоосон хугацаанд зохицуулалт үйлчилгээний хөлсийг төвлөрүүлэх;

1.3.4. Даатгалын тухай болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн дагуу Хорооны хяналт, шалгалтад хамрагдах;

1.3.5. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан дотоод хяналтын хөтөлбөр боловсруулан мөрдөж ажиллах;

Хоёр. Нэр томъёоны тодорхойлолт

2.1. Энэхүү журамд хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

2.1.1. “даатгалын үйл ажиллагаа” гэж Даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад заасан үйл ажиллагааг;

2.1.2. “даатгалын байгууллага” гэж ердийн даатгалын, урт хугацааны даатгалын, давхар даатгалын, даатгалын зуучлагчийн, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагааны аль нэгийг эрхлэхээр тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээдийг;

2.1.3. “Албан журмын даатгагчдын холбоо” гэж Даатгалын тухай хуулийн 12¹ дугаар зүйлийн 12¹.1 дэх хэсэгт заасан холбоог;

2.1.4. “хүртгэмжтэй даатгал” гэж иргэн бүрийг хамруулах зорилго бүхий, даатгалын гэрээний үг хэллэг нөхцөл нь энгийн ойлгомжтой, даатгалын хураамжийн хэмжээ болон нөхөн төлбөр олгохоос татгалзах нөхцөлийн тоо бага байх сайн дурын даатгалын бүтээгдэхүүнийг;

2.1.6.“даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа” гэж даатгагч болон даатгуулагчаас олгосон бүрэн эрхийн дагуу, түүний ашиг сонирхлын төлөө, хэлцэл хийх этгээдтэй холбож өгөх үйл ажиллагааг;

2.1.7.“даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа” гэж даатгагч болон даатгуулагчийн нэрийн өмнөөс даатгалын гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг хянан шалгах, бодит хохирлын хэмжээг тогтоох, талуудын хооронд хэлэлцээ хийх чиг үүргийг бие даан хэрэгжүүлэх үйл ажиллагааг;

2.1.8.“даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа” гэж даатгагчийн хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, түүний нэрийн өмнөөс хэлцэл хийх үйл ажиллагааг;

2.1.9.“салбар, төлөөлөгчийн газар” гэж Компанийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэгт заасан нэгжийг;

Гурав. Тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага

3.1.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн хуулийн этгээдэд тавигдах шаардлага:

3.1.1.хувьцаат компани /ХК/ болон хязгаарлагдмал хариуцлагатай компани /ХХК/ хэлбэрээр байгуулагдсан байх;

3.1.2.компанийг ХК хэлбэрээр байгуулах тохиолдолд Хороо тусгай зөвшөөрөл олгохоор шийдвэрлэсний дараа Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу үнэт цаасаа Хороонд бүртгүүлэх;

3.1.3.хуулийн этгээд нь Хорооноос баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх заавар” /цаашид “Бөглөх, бүрдүүлэх заавар” гэх/-ын дагуу өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралт (А) маягт СЗХ04001-ын дагуу гаргаж, 2 дугаар хавсралт (А)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг бүрдүүлэн Хороонд цаасаар болон цахимаар ирүүлсэн байх;

3.1.4.Хорооноос баталсан “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу боловсруулсан компанийн үйл ажиллагааны гураваас доошгүй жилийн хугацаатай бизнес төлөвлөгөөтэй байх;

3.1.5.Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан хувь хүн, хуулийн этгээд нь тус зааврын дагуу тохиромжтой этгээдийн шалгуур хангасан байх;

3.1.6.компанийн үйл ажиллагааг хэвийн явуулах ажлын байр, техник тоног төхөөрөмж, даатгал, санхүү, бүртгэлийн програм хангамжтай байх эсхүл эдгээрийг худалдан авахаар гэрээ хийсэн байх;

3.1.7.компанийн дүрмийн санг Даатгалын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт нийцүүлсэн байх бөгөөд дүрмийн сангийн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотолсон байх;

3.1.8.Хорооноос тогтоосон шаардлагыг хангасан зах зээлд нийлүүлэх 2-оос доошгүй даатгалын бүтээгдэхүүнтэй байх;

3.1.9.даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон компанийн нэртэй ижил нэр, лого, хэвлэмэл хуудас, даатгалын гэрээ, даатгалын гэрээний баталгаа зэргийг ашиглаагүй байх;

хангасан даатгалын актуартай мөн даатгалын андеррайтертай байх;

3.1.11.компанийн хувь нийлүүлэгчид нь өөр аль нэг даатгалын байгууллагын Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид “ТУЗ” гэх/-ийн дарга, гишүүн, хамтын гүйцэтгэх удирдлагын гишүүн, эрх бүхий албан тушаалд томилогдон ажиллаагүй байх;

3.1.12.Хороо үйл ажиллагааны онцлогтой нь холбогдуулан нарийвчилсан тодруулга болон нэмэлт баримт бичгийг ирүүлэх шаардлага тавьж болох бөгөөд уг шаардлагыг хангасан байх;

3.1.13.давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээдэд энэ журмын 3.1.1-3.1.12-д зааснаас гадна дараах нэмэлт шаардлага тавигдана:

3.1.13.а.давхар даатгалын компанийн алдагдлаас хамгаалах санг 15.0 /арван таван/ тэрбум төгрөгөөс доошгүй хэмжээтэйгээр байгуулсан байх бөгөөд энэ хэмжээг Хороо давхар даатгалын үйл ажиллагааны цар хүрээнээс хамааран нэмэгдүүлэн тогтоож болох ба уг сангийн мөнгөн хөрөнгийн зарцуулалт, зохицуулалттай холбоотой журмыг Хороо батална;

3.1.13.б давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компани нь зөвхөн тухайн үйл ажиллагааг дагнан эрхэлнэ.

3.2.даатгалын зуучлагч болон хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн этгээдэд тавигдах ерөнхий шаардлага:

3.2.1.энэ журмын 3.1.1-3.1.6, 3.1.11, 3.1.12-д заасан шаардлагыг хангасан байх;

3.2.2.хуулийн этгээд бол үнэлгээний доод хэмжээ нь 50.0 /тавин/ сая төгрөг байх мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдахаар хэлцэл хийсэн байх;

3.2.3.компанийн тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагааг хариуцан ажиллах /даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа , даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх/ ажилтан нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан тухайн эрхлэх үйл ажиллагааны чиглэлийн мэргэшлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх;

3.2.4.эрхлэх үйл ажиллагааны дотоод журамтай байх.

3.3.Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нэмэлт шаардлага:

3.3.1.даатгалын зуучлагчийн дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээ нь ердийн болон урт хугацааны даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 20.0 /хорин/ сая төгрөг байх ба дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлосон байх;

3.3.2.давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 3.2.1, 3.2.3.,3.2.4-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

3.3.2.а.давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээ нь 50.0 /тавин/ сая төгрөг байх ба дүрмийн сангийн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотолсон байх;

3.3.2.б.үнэлгээний доод хэмжээ нь 100.0 /нэг зуун/ сая төгрөг байх мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдахаар хэлцэл хийсэн байх;

3.3.2.в.давхар даатгалын зуучлагчийн чиглэлээр мэргэшсэн ажилтантай байх.

3.3.3.даатгалын зуучлагч нь Монгол банкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банк, түүний хараат болон охин компани байж болох бөгөөд өргөдөл гаргагч нь банк, түүний хараат болон охин компани бол энэ журмын 3.2-д зааснаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангана:

захирлын шийдвэрээр байгуулсан буюу томилсон байх;

3.3.3.6. хамтран ажиллах даатгагч бүртэй гүйлгээ хийх тусгайлсан данстай байх;

3.4. Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах нэмэлт шаардлага:

3.4.1. даатгалын хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн мөнгөн хөрөнгийн доод хэмжээ нь Улаанбаатар хотод 10.0 /арван/ сая төгрөг, хөдөө орон нутагт 7.0 /долоон/ сая төгрөг байна.

3.4.2. эрхлэх даатгалын хэлбэрийн хүрээнд мэргэшсэн ажилтантай байх бөгөөд эд хөрөнгөд учирсан бодит хохирлыг тогтоох тохиолдолд Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй нэгээс доошгүй ажилтантай байх бөгөөд тухайн мэргэшсэн ажилтан өөрчлөгдсөн тохиолдолд ажлын 5 хоногийн дотор энэ журмын 1 дүгээр хавсралт (Д) СЗХ04006 маягтын дагуу тодорхойлолт гаргаж Хороонд мэдэгдэх;

3.4.3. даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх компани нь тухайн чиглэлийн үйл ажиллагааг хийж гүйцэтгэхэд шаардлагатай судалгаа, тоон мэдээллийн сантай байх;

3.5. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага:

3.5.1. Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтанд хамрагдаж, шалгалтад тэнцсэн байх бөгөөд даатгалын төлөөлөгч нь хэрэв хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ажилтнууд нь энэхүү шаардлагыг хангасан байх;

3.5.2. даатгагчтай бичгээр байгуулсан хамтран ажиллах гэрээтэй байх бөгөөд тус гэрээнд даатгалын төлөөлөгчийн шимтгэл олгох нөхцлийг хууль тогтоомжид нийцүүлэн тусгасан байх;

3.5.3. зөвхөн энэ журмын 3.5.2-т заасан даатгагчийн төлөөлөгчөөр ажиллах;

3.5.4. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4-т заасан “нийтийн албан тушаалтан” биш байх бөгөөд даатгалын төлөөлөгч нь хэрэв хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх ажилтнууд нь энэхүү шаардлагыг хангасан байх;

3.5.5. тусгай зөвшөөрөл хүссэн этгээд нь “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралт (Б) СЗХ04002 маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (Б)-д дурдсан баримт бичгүүдийг бүрдүүлэн Хороонд цаасаар болон цахимаар ирүүлсэн байх;

3.5.6. Хорооноос хадгаламж, зээлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан хуулийн этгээд нь даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэж болох бөгөөд энэ журмын 3.5.1-3.5.5-д заасан шаардлагыг хангахаас гадна дараах нэмэлт шаардлагыг хангасан байна:

3.5.6.а. даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх хадгаламж, зээлийн хоршоо нь тус хоршооны гишүүдээс бусад этгээдэд даатгалын гэрээ борлуулахгүй байх;

3.5.6.б. Хадгаламж, зээлийн хоршооны тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан хоршооны дүрмийн эрхлэх үйл ажиллагааны төрөлд даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрлийн үйл ажиллагаа эрхлэх зохицуулалтыг тусгасан байх;

3.5.7. гадаадын иргэн Монголын даатгалын компанийн төлөөлөгчөөр ажиллах бол нэмэлт шаардлага, баримт бичиг Хороо шаардаж болно.

3.5.8. Гадаадын даатгагчийн төлөөлөгчийг Монголд ажиллуулах асуудлыг Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11 дэх заалтын дагуу Хорооноос баталсан журмаар зохицуулна.

4.1. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн этгээдийн ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Хорооноос баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягт нөхөх, баримт бичиг хянах заавар”-ын дагуу хянаж, шаардлагатай тохиолдолд газар дээрх шалгалт хийсний үндсэн дээр даатгалын болон даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар, даатгалын төлөөлөгчийн тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг Хорооны дарга шийдвэрлэнэ.

4.2. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох эсэхийг тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл, холбогдох баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 30 хоногийн дотор шийдвэрлэх бөгөөд шаардлагатай тохиолдолд шийдвэрлэх хугацааг Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дах хэсэгт заасан хугацаа хүртэл сунгаж болно.

4.3. Энэ журмын 4.1-д заасан Хорооны шийдвэр, улсын тэмдэгтийн хураамж болон зохицуулалт үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн тухайн этгээдэд Хороо тусгай зөвшөөрлийн гэрчилгээг олгоно.

4.4. Тусгай зөвшөөрөл олгогдсонтой холбоотойгоор гарсан өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгүүлсэн улсын бүртгэлийн гэрчилгээ, компанийн дүрмийн хуулбар, түүний цахим хувилбарыг Хороонд ирүүлнэ.

4.5. Хороо нь дараах үндэслэлээр даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана. Үүнд:

4.5.1. Даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт болон энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;

4.5.2. хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон;

4.5.3. хувьцаа эзэмшигчид нь санхүүгийн зах зээлд оролцогчийн хувьд буюу шунахай сэдэлтээр гэмт хэрэг үйлдэж, ял шийтгэлтэй нь тогтоогдсон, эсхүл ял шийтгэлгүйд тооцох хугацаа дуусаагүй;

4.5.4. Хорооноос даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг нь хүчингүй болгосон өдрөөс хойш 2 жил болоогүй;

4.5.5. бусад хууль болон журамд заасан шаардлагыг хангаагүй.

4.6. Тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан тохиолдолд Хороо энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ.

4.7. Энэ журмын 4.5-д заасан үндэслэлээр тусгай зөвшөөрлийн өргөдлийг буцаах шийдвэрийг Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хариуцсан газрын дарга гаргах бөгөөд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр хүргүүлнэ.

4.8. Хороо хуурамч баримт бичиг бүрдүүлсэн үндэслэлээр даатгалын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзсан (буцаасан) бол татгалзсанаас (буцааснаас) хойш 2 жилийн дотор тухайн компанийн хувьцаа эзэмшигчид, гүйцэтгэх удирдлага (гүйцэтгэх захирал, ерөнхий нягтлан бодогч, эсхүл тэдгээртэй адилтгах албан тушаал)-д ажиллах этгээдээс даатгалын тусгай зөвшөөрөл хүссэн хүсэлтийг хүлээн авахгүй.

4.9. Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх харилцааг Даатгалын тухай хуулийн 69, 71 дүгээр зүйлд заасны дагуу, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл

4.10.Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлсэн тохиолдолд тусгай зөвшөөрлийг сэргээнэ. Зөрчлийг арилгасныг нотлох баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 30 хоногийн дотор тусгай зөвшөөрлийг сэргээх эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

4.11.Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг Даатгалын тухай хуулийн 70, 71 дүгээр зүйлд заасны дагуу, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох харилцааг Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулна.

4.12.Тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн огноо, Хорооны шийдвэрийн дугаарыг тэмдэглэнэ.

Тав. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаатай холбогдох зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах

5.1.Даатгагчийн дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-гийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох

5.1.1.даатгагч нь дүрмийн сангийнхаа өөрчлөлтийн талаар тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авна. Зөвшөөрлийг авахдаа эдгээр өөрчлөлтийн дагуу аливаа гүйлгээ, төлбөр хийхээс өмнө “Бөглөх бүрдүүлэх заавар”-ын дагуу зөвшөөрлийн өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралт (В) СЗХ04003маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (В)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсарган Хороонд ирүүлсэн байна.

5.1.2.дүрмийн санд оруулсан хөрөнгө нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сэжиг бүхий гэж үзвэл Хороо нэмэлт мэдээлэл шаардаж болно.

5.1.3.даатгагч нь уг зөвшөөрөл хүссэн өөрчлөлттэй холбоотойгоор дүрмийн санд нэмэгдсэн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотолсон байх ба Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын 1.2-д заасан этгээдүүд нь тус зааврын шаардлагыг хангасан байна.

5.1.4.дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгохыг хүсч ирүүлсэн өргөдөл, холбогдох баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу хянаж, зөвшөөрөл олгох эсэх асуудлыг Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

5.1.5.даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгох эсэхийг баримт бичгийн бүрдэл гүйцэд болсон өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.2.Даатгалын байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл олгох

5.2.1.даатгалын байгууллага нь салбар, төлөөлөгчийн газар нээх, татан буулгах зөвшөөрлийг Хорооноос авах бөгөөд Хороо зөвшөөрөл олгох эсэх асуудлыг зөвшөөрөл хүссэн баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн Монгол Улсын нутаг дэвсгэрт салбар, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд ажлын 14 хоногийн дотор, гадаад улсад салбар, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд ажлын 45 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.2.2.Монгол Улсад гадаадын даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч салбар, төлөөлөгчийн газраа нээх, түүгээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохтой холбогдсон харилцааг Даатгалын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.7 дахь заалтад заасан эрх зүйн актын хүрээнд зохицуулах бөгөөд энэ журмын 5.2.1 дэх заалт хамаарахгүй.

байршил нь тодорхой, байнгын ажлын байртай байх;

5.2.3.б.Хороо, холбогдох мэргэжлийн холбоодоос зохион байгуулсан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн 1-ээс доошгүй ажилтантай байх;

5.2.3.в.салбарын удирдлага, ажилтан, гэрээт ажилтнаар ажиллах этгээд нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.4 дэх заалтад заасан “нийтийн албан тушаалтан” биш байх;

5.2.3.г.үйл ажиллагааг хэвийн явуулах тоног төхөөрөмж, програм хангамжтай байх;

5.2.3.д.нэгж нь компанийн ерөнхий захиргаа болон бусад нэгжүүдтэйгээ мэдээллийн нэгдсэн нэг сүлжээнд холбогдож, мэдээлэл, тайлагнал дамжуулдаг байх;

5.2.3.е.тухайн нутаг дэвсгэрт салбар нээн ажиллуулахтай холбогдсон зах зээлийн судалгаа, бизнес төлөвлөгөөнд гарсан өөрчлөлтийг тусгасан 3-аас доошгүй жилийн үйл ажиллагааны бизнес төлөвлөгөөтэй байх;

5.2.3.ё.эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрийг тодорхой тусгасан, салбарын дотоод хяналт болон бусад үйл ажиллагааг зохицуулах журамтай байх.

5.2.4.даатгалын компанийн салбар нь энэ журмын 5.2.3-т зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

5.2.4.а.арилжааны банкны салбарт данстай байх;

5.2.4.б.салбар нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд шуурхай албатай байх ба 24 цагаар дуудлага хүлээн авах суурин утастай, тээврийн ослын хохирлын хэмжээг газар дээр нь очиж тогтоох зориулалтын автомашинтай, даатгалын талаарх мэдээлэл оруулж хадгалах, шаардлагатай мэдээг мэдээллийн санд өгч нэгтгүүлэх интернэтэд холбогдсон програм хангамжтай байх;

5.2.4.в.даатгалын компанийн салбар нь шуурхай албаны үйл ажиллагааг Албан журмын даатгагчдын холбоо эсхүл дээрх шаардлагыг хангасан шуурхай албаны үйлчилгээг үзүүлдэг байгууллагатай гэрээ байгуулан гүйцэтгүүлж болно. Даатгагчтай гэрээ байгуулсан шуурхай албаны үүрэг гүйцэтгэгч байгууллага нь энэ журмын 5.2.4.б, Жолоочийн даатгалын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасныг зөрчсөн тохиолдолд тухайн гэрээ байгуулсан даатгагчийн салбар нь жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг хангахгүй байна гэж үзэх үндэслэл болно.

5.2.5.даатгалын хохирол үнэлэгчийн салбар нь энэ журмын 5.2.3-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд эрхлэх даатгалын хэлбэрийн хүрээнд эд хөрөнгөд учирсан бодит хохирлыг тогтоох тохиолдолд Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрөлтэй нэгээс доошгүй ажилтантай байна.

5.2.6.даатгалын зуучлагчийн салбар нь тухайн орон нутагт Хорооноос салбар нээх зөвшөөрөл аваагүй даатгагчийн бүтээгдэхүүнийг зуучлан борлуулахыг хориглоно.

5.2.7.даатгалын зуучлагч нь банк бол даатгалын зуучлалын үйл ажиллагааг банкны нэгжээр дамжуулан хийж болох бөгөөд дараах шаардлагыг хангасан нэгж нь Хороонд бүртгүүлсэн даатгалын хэлбэрийн бүтээгдэхүүнийг зуучлан борлуулж болно:

5.2.7.а.Хороо, холбогдох мэргэжлийн холбоодоос зохион байгуулсан даатгалын зуучлагчийн мэргэшлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн даатгалын зуучлагчийн үйл

5.2.8.даатгалын зуучлагч банк болон банкны нэгж нь энэ журмын 5.2.7.а-д заасан шаардлагыг хангахгүй тохиолдолд зөвхөн тухайн банкны бүтээгдэхүүнд холбогдох даатгалын бүтээгдэхүүнийг зуучлан борлуулж болно.

5.2.9.даатгалын байгууллагын төлөөлөгчийн газар нь энэ журмын 5.2.3.а, 5.2.3.д-д заасан шаардлагыг хангасан байх бөгөөд даатгагч болон даатгалын зуучлагчийн төлөөлөгчийн газар нь даатгалын гэрээ байгуулах, даатгалын гэрээг зуучлан борлуулах, даатгалын хохирол үнэлэгчийн төлөөлөгчийн газар нь даатгалын зүйлийн бодит хохирлын хэмжээг тогтоох үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

5.2.10.даатгалын байгууллага нь гадаад улсад салбар нээх тохиолдолд энэ журмын 5.2.3-т заасан, төлөөлөгчийн газар нээх тохиолдолд энэ журмын 5.2.9-д заасан шаардлагыг хангахаас гадна дараах нэмэлт шаардлага тавигдана:

5.2.10.а.даатгагч бол Хорооноос баталсан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг сүүлийн нэг жилийн хугацаанд хангасан, таваас доошгүй жилийн даатгалын үйл ажиллагааны дадлага, туршлагатай байх ба Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын шаардлагыг хангасан удирдлагатай байх.

5.2.10.б.даатгалын мэргэжлийн оролцогч бол гураваас доошгүй жилийн даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны дадлага, туршлагатай байх ба Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын шаардлагыг хангасан удирдлагатай байх.

5.2.10.в.Хороо даатгалын байгууллагын тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл, журамд заасан эрхлэх даатгалын ангилал, төрөл, хэлбэрээс хамааран шаардлагатай гэж үзсэн нэмэлт нөхцөл, шаардлага тавьж болно.

5.2.11.даатгалын байгууллага нь салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл авахдаа “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу зөвшөөрлийн өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралт (В) СЗХ04003 маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (Г)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсарган Хороонд ирүүлсэн байна:

5.2.11.а.энэ журмын 5.2.10.в-д заасан нэмэлт нөхцөл, шаардлагын дагуу Хороо шаардлагатай гэж үзвэл нэмэлт мэдээлэл шаардаж болно.

5.2.12.Хороо энэ журмын 5.2.11-д дурдсан баримт бичгийг хянан үзэж, салбар, төлөөлөгчийн газар нээх нь тухайн хуулийн этгээдийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, үйлчлүүлэгчдэд хохирол учруулахгүй гэж үзсэн, боловсон хүчин, техник тоног төхөөрөмж нь тухайн салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг хангаж байна гэж үзвэл зөвшөөрөл олгох шийдвэрийг Хорооны дарга гаргана.

5.2.13.Хорооны даргын шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад салбар, төлөөлөгчийн газрын талаарх тэмдэглэлийг хийж баталгаажуулах бөгөөд даатгалын байгууллагын нэгжийн гэрчилгээг олгоно.

5.2.14. даатгалын байгууллага нь салбар, төлөөлөгчийн газрын үйл ажиллагааг хязгаарлах, өөрчлөн байгуулах (нэгтгэх, нийлүүлэх, салгах, тусгаарлах, өөрчлөх), байршлыг нь өөрчлөх тухай бүрд шийдвэр гаргаж, уг шийдвэрийг гаргасан өдрөөс хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд ирүүлж бүртгүүлнэ.

5.2.15.даатгалын байгууллага нь гадаад улсаас салбар төлөөлөгчийн газар ажиллуулах зөвшөөрлийг авснаас хойш ажлын 30 хоногийн дотор Хороонд салбар, төлөөлөгчийн газрын албан ёсны хаяг, холбоо барих утас, эрх бүхий этгээдийн талаар албан бичгээр мэдэгдэж, холбогдох баримтыг хавсаргана. Энэ мэдэгдлийг үндэслэн Хороо даатгалын байгууллагын

5.2.16.даатгалын байгууллага нь Хорооноос олгосон салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрөлгүйгээр компанийн оршин байгаа газраас өөр газарт даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн болон түүнтэй холбоотой үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

5.2.17.даатгалын байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрлийг дараах үндэслэлээр Хорооны даргын шийдвэрээр хүчингүй болгож тусгай зөвшөөрлийн гэрчилгээнд ажлын 5 хоногийн дотор тэмдэглэл хийнэ. Үүнд:

5.2.17.а.даатгалын байгууллагын шийдвэрээр;

5.2.17.б.даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, түүний салбар нь санхүүгийн хүндрэлд орсон, холбогдох хууль тогтоомжид нийцээгүй үйл ажиллагаа явуулсан; зөвшөөрөл олгосноос хойш 6 сарын хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, Хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлээгүй, зөвшөөрөл олгосон нөхцөл шаардлагыг хангаагүй, тухайн салбар, төлөөлөгчийн газар тухайн даатгагч эсхүл мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл Хорооны шийдвэрээр;

5.2.17.в.гадаад улсад нээсэн даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн салбарын хувьд тухайн улсын харьяалах хяналтын байгууллагаас гаргасан шийдвэрээр;

5.2.17.г.хууль тогтоомжид заасан бусад үндэслэлээр.

5.2.18.Хороо энэ журмын 5.2.17.б, 5.2.17.в, 5.2.17.г-д заасан үндэслэлээр даатгалын байгууллагын салбар, төлөөлөгчийн газрын зөвшөөрлийг хүчингүй болгож байгаа бол даатгалын байгууллагад энэ тухай ажлын 2 хоногийн дотор албан бичгээр мэдэгдэнэ.

5.3.Даатгалын байгууллагын оноосон нэрийг өөрчлөх зөвшөөрөл олгох

5.3.1.даатгалын байгууллага өөрийн оноосон нэрийг өөрчлөх зөвшөөрлийг Хорооноос авах бөгөөд “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу зөвшөөрлийн өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралт (В) СЗХ04003 маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (Д)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсарган Хороонд ирүүлсэн байна.

5.3.2.Хороо хүсэлтийг хянаж, нэрээ өөрчлөх нь үйлчлүүлэгчдэд сөргөөр нөлөөлөхгүй, төөрөгдүүлэхгүй гэж үзвэл тухайн хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрөх эсэхийг Хорооны хуралдаанаар шийдвэрлэх бөгөөд зөвшөөрөл олгох, эсэх асуудлыг зөвшөөрөл хүссэн баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.3.3.Хорооны шийдвэр болон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримтыг үндэслэн Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн гэрчилгээг эргүүлэн авч, оноосон нэрийг өөрчилсөн тусгай зөвшөөрлийн гэрчилгээг шинээр олгоно.

5.3.4.компанийн өмнөх нэр дээр үүссэн эрх, үүрэг эрх залгамжлалын журмаар шинэ нэрээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдэд бүрэн шилжинэ.

5.3.5.даатгалын байгууллагын оноосон нэрийг өөрчлөх зөвшөөрөл олгох тухай Хорооны шийдвэр гарсны дараа ажлын 3 хоногийн дотор даатгалын байгууллага нь энэ талаар нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдээлнэ.

5.4. Даатгагчийн эрх бүхий албан тушаалтныг томилох зөвшөөрөл олгох

5.4.1.даатгалын компанийн эрх бүхий албан тушаалтан нь шинээр томилогдох болон өөрчлөгдөх тухай бүр Хороонд мэдэгдэж, зөвшөөрөл авах бөгөөд Хороо зөвшөөрөл олгох эсэх асуудлыг зөвшөөрөл хүссэн баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.4.2.даатгалын компани эрх бүхий албан тушаалтныг томилох зөвшөөрөл авахдаа “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу зөвшөөрлийн өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралт

5.4.3.даатгалын компанийн шинээр томилогдох эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын шаардлагыг хангасан байна.

5.4.4.даатгалын компанийн эрх бүхий албан тушаалтныг томилох зөвшөөрлийг Хорооны дарга олгоно.

5.5. Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох

5.5.1.албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авахыг хүссэн даатгагч дараах шаардлагыг хангасан байна:

5.5.1.а.нэгээс доошгүй жилийн хугацаанд даатгалын үйл ажиллагаа эрхлэж, олон нийтэд танигдсан туршлагатай байх;

5.5.1.б.Хорооноос батлагдсан журмын дагуу төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг сүүлийн 2 улирал дараалан хангасан байх;

5.5.1.в.албан журмын даатгалын үйл ажиллагаанд ашиглах програм хангамж, мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх боловсон хүчинтэй байх;

5.5.1.г.жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагааг зөвхөн ердийн даатгалын компани эрхлэх бөгөөд энэ тохиолдолд даатгагч нь даатгалын тохиолдлыг шалгах шуурхай албатай байх;

5.5.2.албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл хүссэн этгээд нь “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу зөвшөөрлийн өргөдлөө энэ журмын 1 дүгээр хавсралт (В) СЗХ04003 маягтын дагуу гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (Ж)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсарган Хороонд ирүүлсэн байна.

5.5.3.албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгохыг хүсч даатгагчаас ирүүлсэн баримт бичгийг холбогдох хууль тогтоомж болон энэ журмын дагуу хянаж, шаардлагатай тохиолдолд газар дээрх шалгалт хийсний үндсэн дээр тухайн даатгагчийн санхүүгийн чадварт сөргөөр нөлөөлөхгүй, нийтийн болон даатгуулагчийн ашиг сонирхолд хохирол учруулахгүй гэж үзвэл албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох эсэхийг баримт бичгийн бүрдэл хангагдсан өдрөөс хойш ажлын 14 хоногийн дотор Хорооны хуралдаанаар шийдвэрлэнэ.

5.5.4.Хорооны тогтоолыг үндэслэн тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтад албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх нутаг дэвсгэрийг заасан тэмдэглэгээг хийж баталгаажуулна.

5.6. Зөвшөөрөл олгохоос татгалзах

5.6.1.Хороо нь дараах үндэслэлээр энэ журмын 5.1-5.5-д заасан зөвшөөрөл олгохоос татгалзаж, энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг даатгалын байгууллагад албан бичгээр хүргүүлнэ. Үүнд:

5.6.1.а.энэ журамд заасан холбогдох шаардлагыг хангаагүй;

5.6.1.б.хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь нотлогдсон;

5.6.1.в.бусад хууль, журамд заасан шаардлагыг хангаагүй.

5.6.2.энэ журмын 5.6.1-д заасан үндэслэлээр зөвшөөрлийн өргөдлийг буцаах шийдвэрийг Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хариуцсан газрын дарга гаргах бөгөөд үндэслэл бүхий тайлбарыг өргөдөл гаргагчид албан бичгээр хүргүүлнэ.

6.1.Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний бүртгэл

6.1.1.даатгалын компани нь эрхлэх сайн дурын даатгалын хэлбэрт өөрчлөлт оруулах тухай бүр, мөн даатгалын бүтээгдэхүүнийг зах зээл дээр борлуулахаас өмнө, бүтээгдэхүүний даатгалын гэрээний нөхцөл, шаардлагууд өөрчлөгдсөн тухай бүр, даатгалын мэргэжлийн оролцогч нь эрхлэх даатгалын хэлбэрт өөрчлөлт оруулах тухай бүр Хороонд бүртгүүлнэ.

6.1.2.Хороонд энэ журмын 6.1.1-д заасан бүртгэлийг хийлгэхдээ “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу энэ журмын 1 дүгээр хавсралт (Г) СЗХ04004 маягтын дагуу өргөдөл гаргаж энэ журмын 2 дугаар хавсралт (З)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсарган Хороонд ирүүлсэн байна.

6.1.3.даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч нь бүртгүүлэх даатгалын хэлбэрийн талаар мэдлэг, туршлагатай ажилтантай байх шаардлагатай.

6.1.4.тусгай зөвшөөрлийн дагуу эрхлэх даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг бүртгүүлэх баримт бичигийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн ажлын 10 хоногийн дотор Хорооны даатгалын зохицуулалтын асуудал эрхэлсэн газар хянаж, бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ.

6.1.5.даатгалын хэлбэр, ирүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээнээс хамааран шаардлагатай тохиолдолд даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг бүртгэх эсэхийг шийдвэрлэх хугацааг сунгаж болно.

6.1.6.орон сууцны урт хугацааны зээлийн даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавина:

6.1.6.а.ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч “Орон сууцны зээлийн барьцаа хөрөнгийн даатгалын гэрээ”-г борлуулахад, Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан даатгагч “Орон сууцны зээлдэгчийн амь насны даатгалын гэрээ”-г борлуулахад энэ нэр томъёоноос өөрөөр даатгалын бүтээгдэхүүний гэрээг нэрлэхийг хориглох бөгөөд эдгээр бүтээгдэхүүнийг багцалж борлуулах нөхцөлд “Орон сууцны зээлийн даатгалын гэрээ” гэж томъёолох;

6.1.7.хурдан морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавина:

6.1.7.а.даатгалын эрсдэлд үндэсний баяр наадам болон бүх түвшний хурдан морины уралдаан, түүний бэлтгэл, сунгааны үед үүсч болзошгүй бүхий л гэнэтийн осол, гэмтэл болон даатгалын гэрээний хугацаанд бий болж болзошгүй бусад ахуйн гэмтэл, ослыг тусгах;

6.1.8.хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавина:

6.1.8.а.даатгалын хураамж болон эрсдэлийн хэмжээ нь бага, дунд орлоготой иргэдэд зориулагдсан байх;

6.1.8.б.даатгалын гэрээнд тусгасан нөхөн төлбөрийн хасалтын тоо 5-аас ихгүй байх;

6.1.8.в.даатгалын гэрээ нь хоёрдмол утга санаагүй, бусдад шууд ойлгохоор үг, хэллэгтэй байх;

6.1.8.г.даатгалын нөхөн төлбөрийг ажлын 10 хоногт олгодог байх.

6.1.9.энэ журмын 6.1.8-д заасан хүртээмжтэй даатгалын бүтээгдэхүүнийг Хороо бүртгэхдээ код өгөх бөгөөд уг код нь “ХД” үсгийн ард дугаар, оныг илэрхийлсэн цифрийг

6.1.10.тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэхэд Хороо дараах шаардлагыг тавина:

6.1.10.а.тээврийн хэрэгслийн даатгалын бүтээгдэхүүний гэрээнд тээврийн хэрэгслийн үзлэг оношлогоонд ороогүй тээврийн хэрэгсэлд нөхөн төлбөр олгохгүй, мөн богино холболтын улмаас галд шатах, замын хөдөлгөөний дүрэм зөрчсөн, техникийн шаардлага хангаагүй зэрэг ерөнхий нөхцөлийг тусган даатгуулагчид нөхөн төлбөр олгохоос татгалзах заалтыг даатгалын гэрээнд тусгахыг хориглоно.

6.1.11.даатгагч Хороонд бүртгүүлсэн даатгалын гэрээний загвараас өөр нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулахыг хориглоно.

6.1.12.даатгалын бүтээгдэхүүний нөөц сан, хураамжийн хэмжээний тооцоолол, даатгалын гэрээний загварын Иргэний хуулийн 431 дүгээр зүйлийн 431.4 дэх хэсэгт заасан нөхцөлүүдийн аль нэг нь болон хэд хэдэн нөхцөл өөрчлөгдсөн тохиолдолд даатгалын бүтээгдэхүүний өөрчлөлтийг энэ журмын 6.1.2-д заасны дагуу баримт бичгийг бүрдүүлэн Хороонд бүртгүүлнэ.

6.1.13.энэ журамд заасан холбогдох шаардлагыг хангаагүй даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг Хорооны даатгалын зохицуулалтын асуудал эрхэлсэн газрын дарга бүртгэхээс татгалзана.

6.1.14.Хороонд бүртгүүлээгүй даатгалын бүтээгдэхүүнийг борлуулах, Хороонд бүртгүүлээгүй даатгалын хэлбэрээр даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

6.2.Даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийн бүртгэл

6.2.1.даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан шинээр томилогдох, өөрчлөгдөх тухай бүр ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэж, бүртгүүлэх бөгөөд Хороо ажлын 5 хоногийн дотор ирүүлсэн баримт бичгийг хянаж, Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хариуцсан газрын дарга бүртгэх эсэхийг шийдвэрлэнэ. Бүртгэл хүссэн баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс эхлэн шийдвэрлэх хугацааг тооцно.

6.2.2.даатгалын мэргэжлийн оролцогч нь эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэхдээ “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу энэ журмын 1 дүгээр хавсралт (Г) СЗХ04004 маягтын дагуу өргөдөл гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (И)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсарган Хороонд ирүүлсэн байна.

6.2.3.даатгалын мэргэжлийн оролцогчийн шинээр томилогдох эрх бүхий албан тушаалтан нь Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-ын шаардлагыг хангасан байна.

6.2.4.энэ журамд заасан холбогдох шаардлагыг хангаагүй эсхүл хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон тохиолдолд даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хариуцсан газрын дарга бүртгэхээс татгалзана.

6.2.5.Хороонд бүртгүүлээгүй эсхүл Хороо бүртгэхээс татгалзсан этгээдийг даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтанд томилохыг хориглоно.

6.3.Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн дүрмийн сан (хувь нийлүүлсэн хөрөнгө)-гийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийн бүртгэл

өөрчлөлтийн дагуу аливаа гүйлгээ, төлбөр хийхээс өмнө “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу энэ журмын 1 дүгээр хавсралт (Г) СЗХ04004 маягтын дагуу өргөдөл гаргаж, энэ журмын 2 дугаар хавсралт (К)-д дурдсан бүрдүүлэх баримт бичгүүдийг хавсарган Хороонд ирүүлсэн байна:

6.3.1.а.дүрмийн санд оруулсан хөрөнгө нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой сэжиг бүхий гэж үзвэл Хороо нэмэлт мэдээлэл шаардаж болно.

6.3.2.даатгалын зуучлагч, хохирол үнэлэгч нь дүрмийн санд нэмэгдсэн мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотолсон байх ба Хорооноос баталсан “Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар”-т заасан этгээдүүд нь тус зааврын шаардлагыг хангасан тохиромжтой этгээд байна.

6.3.3.дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд орох өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөл, холбогдох баримт бичгийг хууль тогтоомжийн дагуу хянаж, бүртгэх эсэх асуудлыг бүртгэл хүссэн баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлж Хороонд ирүүлсэн өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хариуцсан газрын дарга шийдвэрлэнэ.

6.3.4.Хороонд бүртгүүлээгүй эсхүл Хороо бүртгэхээс татгалзсан нөхцөлд компанийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулахыг хориглоно.

6.3.5.энэ журмын 6.3.1, 6.3.2 дахь заалт нь даатгалын зуучлагч банкинд хамаарахгүй бөгөөд даатгалын зуучлагч банк нь Монгол банкнаас хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрөл олгосноос хойш ажлын 3 хоногийн дотор Монгол банк зөвшөөрөл олгосныг нотлох баримтын хамт энэ журмын 1 дүгээр хавсралтаар батлагдсан СЗХ04003 маягт, шаардлагатай тохиолдолд СЗХ04005 маягтуудыг “Бөглөх, бүрдүүлэх заавар”-ын дагуу бөглөн Хороонд ирүүлж, бүртгүүлнэ.

6.3.6.даатгалын зуучлагч нь давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан тохиолдолд дараах шаардлага тавигдана:

6.3.6.а.энэ журмын 3.3.2.а-3.3.2.в, дүрмийн санг нэмэгдүүлж байгаа тохиолдолд 6.3.1, 6.3.2 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байх;

6.3.6.б.давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх хүсэлтийн хамт “Бөглөх бүрдүүлэх заавар”, энэ журмын 1 дүгээр хавсралт (Е)- СЗХ04006 маягтын дагуу бөглөсөн мэргэшлийн ажилтны тодорхойлолт, мэдлэг, туршлагыг нотлох баримт бичиг болон энэ журмын 3.3.2.б-д заасан шаардлагын дагуу хийгдсэн мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний төслийг Хороонд ирүүлэх.

6.3.7.даатгалын зуучлагч нь давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх хүсэлт гаргасан тохиолдолд энэ журмын 6.3.6 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан гэж үзвэл Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хариуцсан газрын дарга бүртгэх эсэхийг баримт бичгийг бүрэн гүйцэд ирүүлсэн өдрөөс хойш ажлын 20 хоногийн дотор шийдвэрлэнэ.

6.3.8.энэ журмын 6.3.7 дахь хэсэгт заасан шийдвэрийг үндэслэн Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хариуцсан газар давхар даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шаардлагыг хангасан тухай мэдэгдлийг даатгалын зуучлагчид хүргүүлж, тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хавсралтын тусгай зөвшөөрлийн төрөл хэсэгт “давхар даатгалын зуучлагч” гэж нэмж тэмдэглэн баталгаажуулна.

6.3.9.даатгалын зуучлагч нь давхар даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх нөхцөл шаардлагыг хангаагүй тохиолдолд Хорооны тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл хариуцсан газрын дарга хүсэлтийг буцаах шийдвэрийг гаргах бөгөөд энэ талаарх үндэслэл бүхий тайлбарыг хүсэлт гаргагчид албан бичгээр хүргүүлнэ.

6.4.1.даатгалын байгууллага нь өөрийн өрөлхийн захирааны хаяг болон салбар, төлөөлөгчийн газрын хаягийн өөрчлөлтийг хаяг өөрчлөгдсөнөөс хойш ажлын 5 хоногийн дотор Хороонд мэдэгдэж, бүртгүүлэх бөгөөд Хороо ирүүлсэн баримт бичгийг ажлын 5 хоногийн дотор хянаж, бүртгэнэ.

6.4.2.даатгалын байгууллага нь хаягийн өөрчлөлтөө бүртгүүлэхдээ энэ журмын 1 дүгээр хавсралт (Г) СЗХ04004 маягтын дагуу өргөдөл гаргаж, шинэ ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбарыг хавсарган Хороонд ирүүлнэ.

Долоо. Хяналт, хариуцлага

7.1.Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавьж, хууль тогтоомж зөрчсөн этгээдэд Даатгалын хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--

ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ

Тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрийн мэдээлэл					
1	Өргөдөл гаргасан огноо	Он		Сар	Өдөр
2	Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр				
3	Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байсан эсэх	Тийм <input type="checkbox"/> бол үйл ажиллагааны төрлийг бичнэ үү.			Үгүй <input type="checkbox"/>
4					15 луу шилжих/
5	Өмнө нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл ирүүлж байсан эсэх	Тийм <input type="checkbox"/> бол /6,7-г бөглөх/ тусгай зөвшөөрлийн төрлийг бичнэ үү.			Үгүй <input type="checkbox"/>
6					18 луу шилжих/
7		Тусгай зөвшөөрөл олгогдсон <input type="checkbox"/> олгогдоогүй <input type="checkbox"/>			
8	Даатгалын үйл ажиллагаа	<input type="checkbox"/> Ердийн даатгал /9-г бөглөх/ <input type="checkbox"/> Урт хугацааны даатгал /10-г бөглөх/ <input type="checkbox"/> Давхар даатгал			
	Даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа	<input type="checkbox"/> Даатгалын зуучлагч, үүнээс: <input type="checkbox"/> Ердийн даатгалын зуучлагч <input type="checkbox"/> Урт хугацааны даатгалын зуучлагч <input type="checkbox"/> Давхар даатгалын зуучлагч <input type="checkbox"/> Даатгалын хохирол үнэлэгч			
Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх даатгалын хэлбэрийг сонгоно уу.					
9	<input type="checkbox"/> Ердийн даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Гэнэтийн осол, эмчилгээний даатгал <input type="checkbox"/> Хөрөнгийн даатгал <input type="checkbox"/> Автотээврийн хэрэгслийн даатгал <input type="checkbox"/> Ачааны даатгал <input type="checkbox"/> Барилга угсралтын даатгал <input type="checkbox"/> Газар тариалангийн даатгал <input type="checkbox"/> Мал амьтдын даатгал <input type="checkbox"/> Агаарын хөлгийн даатгал <input type="checkbox"/> Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Санхүүгийн даатгал <input type="checkbox"/> Зээлийн даатгал <input type="checkbox"/> Итгэлцлийн даатгал <input type="checkbox"/> Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал <input type="checkbox"/> Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			
10	<input type="checkbox"/> Урт хугацааны даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Хугацаат амьдралын даатгал <input type="checkbox"/> Насан туршийн даатгал <input type="checkbox"/> Хуримтлалын даатгал <input type="checkbox"/> Тэтгэврийн даатгал <input type="checkbox"/> Эрүүл мэндийн даатгал <input type="checkbox"/> Аннуити даатгал			
11	<input type="checkbox"/> Албан журмын даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал			
Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл					
12	Хуулийн этгээдийн нэр	Монгол			

	/хэрэв өөрчлөгдөж байсан бол/		Хэзээнээс ____ / ____ / ____ хүртэл ____ / ____ / ____			
(Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих)						
14	Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр
15	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
16	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай		<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай		
17	Улсын бүртгэлийн дугаар	Гадаадын ХО-ын хувь				
18	Регистрийн дугаар					
19	Хаяг байршил	Аймаг/ хот Сум/дүүрэг Баг/хороо Гудамж,байр Тоот				
20	Холбоо барих утас	Суурин	Гар утас		Факс	
21	Цахим хуудас					
	Цахим шуудангийн хаяг					
	Нийгмийн сүлжээний хаяг					
Банкин дахь харилцах, хадгаламжийн мэдээлэл:						
22	<input type="checkbox"/> Харилцах	Банкны нэр				
		Дансны дугаар				
		Үлдэгдэл /₮/				
	<input type="checkbox"/> Хадгаламж	Банкны нэр				
		Дансны дугаар				
		Үлдэгдэл /₮/				
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:						
23	Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/ оноосон нэр	Хувьцааны тоо (ш), төрлөөр		ХНХ-н хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)	
		Давуу эрхтэй	Энгийн			
24	Компанийн нэгдлийн оролцогч эсэх	Тийм <input type="checkbox"/> /25-г бөглөх/	Үгүй <input type="checkbox"/> /26 луу шилжих/			
25	Оноосон нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөл хүсэгчтэй ямар холбоотой болох		
Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл:						
26	ТУЗ-тэй байх эсэх	Үгүй <input type="checkbox"/> /27 луу шилжих/	Тийм <input type="checkbox"/>	Бүрэлдэхүүний тоо		
27	Дотоод хяналтын нэгжтэй байх эсэх	Үгүй <input type="checkbox"/> /28 луу шилжих/	Тийм <input type="checkbox"/>	Бүрэлдэхүүний тоо		
28	Нийт ажилтан, албан хаагчдын тоо					
29	Даатгалын мэргэжлийн боловсон хүчний тоо		Үүнээс даатгалын актуарчийн тоо /даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол/			
30	Ажлын байрын мэдээлэл:		Худалдаж авсан <input type="checkbox"/>	Түрээсэлсэн <input type="checkbox"/>	Бусад <input type="checkbox"/>	
Ашиглах техник тоног төхөөрөмж, програмхангамжийн мэдээлэл						
31	Техник, тоног	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Тоо	Үнэ ₮	

32	Програм хангамжийн нэр төрөл	Програмын зориулалт	Худалдан авсан Түрээслэсэн /аль нь болохыг бичих/	Тоо ширхэг	Үнэ ₮
Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн төлөвлөлт					
33	Үзүүлэлтүүд		Он	Он	Он
	Нийт хөрөнгө ₮				
	Хувь нийлүүлсэн хөрөнгө ₮				
	Нийт орлого ₮				
	Нийт зардал ₮				
	Ашиг ₮				
34	Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн бол дараах нэмэлт үзүүлэлтүүдийг хүснэгтэд тусгана уу.				
	Нийт даатгалын үнэлгээний дүн ₮				
	Нийт даатгалын хураамжийн орлого ₮				
	Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээ ₮				
	Хохирол нөхөлтийн харьцаа				
	Даатгалын бус үйл ажиллагааны орлого ₮				
	Давхар даатгалын үнэлгээний дүн ₮				
	Давхар даатгалын хураамж ₮				
	Давхар даатгалаас олгох нөхөн төлбөр ₮				

Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д нийцүүлэн даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойших хугацаанд Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр албан тушаал гарын үсэг огноо

Тамга:

**ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ**

Эрхлэх үйл ажиллагааны мэдээлэл					
1	Өргөдөл гаргасан огноо	Он		Сар	
2	Өргөдөл гаргагчийн овог нэр, оноосон нэр				
3	Өмнө нь санхүүгийн салбарт ажиллаж /үйл ажиллагаа явуулж/байсан эсэх	Тийм <input type="checkbox"/> бол үйл ажиллагааны төрлийг бичнэ үү.			Үгүй <input type="checkbox"/>
4					/5 луу шилжих/
5	Өмнө нь тусгай зөвшөөрөл авах хүсэлт ирүүлж байсан эсэх	Тийм <input type="checkbox"/> бол /6,7-г бөглөх/ тусгай зөвшөөрлийн төрлийг бичнэ үү.			Үгүй <input type="checkbox"/>
6					/6 луу шилжих/
7		Тусгай зөвшөөрөл олгогдсон <input type="checkbox"/> олгогдоогүй <input type="checkbox"/>			
Тусгай зөвшөөрлийн хүрээнд эрхлэх сайн дурын даатгалын хэлбэрийг сонгоно уу.					
8	<input type="checkbox"/> Ердийн даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Гэнэтийн осол, эмчилгээний даатгал <input type="checkbox"/> Хөрөнгийн даатгал <input type="checkbox"/> Автотээврийн хэрэгслийн даатгал <input type="checkbox"/> Ачааны даатгал <input type="checkbox"/> Барилга угсралтын даатгал <input type="checkbox"/> Газар тариалангийн даатгал <input type="checkbox"/> Мал амьтдын даатгал <input type="checkbox"/> Агаарын хөлгийн даатгал <input type="checkbox"/> Авто тээврийн хэрэгслийн жолоочийн хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Санхүүгийн даатгал <input type="checkbox"/> Зээлийн даатгал <input type="checkbox"/> Итгэлцлийн даатгал <input type="checkbox"/> Төмөр замын болон усан замын тээврийн хэрэгслийн даатгал <input type="checkbox"/> Төмөр замын эсхүл усан замын тээврийн хэрэгслийг өмчлөх, эзэмших ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал <input type="checkbox"/> Агаарын хөлгийг өмчлөх, эзэмших, ашиглахтай холбоотой хариуцлагын даатгал			
	<input type="checkbox"/> Урт хугацааны даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Хугацаат амьдралын даатгал <input type="checkbox"/> Насан туршийн даатгал <input type="checkbox"/> Хуримтлалын даатгал <input type="checkbox"/> Тэтгэврийн даатгал <input type="checkbox"/> Эрүүл мэндийн даатгал <input type="checkbox"/> Аннуити даатгал			
	<input type="checkbox"/> Албан журмын даатгалын хэлбэр	<input type="checkbox"/> Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал			
9	Өргөдөл гаргагч нь	<input type="checkbox"/> иргэн /10-19-г бөглөх/		<input type="checkbox"/> хуулийн этгээд /20-32-г бөглөх/	
Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх иргэний мэдээлэл					
10	Овог				
11	Нэр				
12	Регистрийн дугаар				
13	Албан ёсны хаяг байршил				
14	Эрхэлж байгаа ажил, албан тушаал				
15	Ажлын хаяг				
16	Эзэмшсэн мэргэжил				

19	Мэргэжлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн эсэх <input type="checkbox"/>					
Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл						
20	Хуулийн этгээдийн нэр	Монгол Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)				
21	Оноосон нэрэнд орсон өөрчлөлт /хэрэв өөрчлөгдөж байсан бол/	Нэр _____ Хэзээнээс ____ / ____ / ____ хүртэл ____ / ____ / ____ (Оноосон нэр өөрчлөгдсөн бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он/сар/өдөр дарааллаар бичих)				
22	Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр
23	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани		<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
24	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай		<input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай Гадаадын ХО-ын хувь _____		
25	Улсын бүртгэлийн дугаар					
26	Регистрийн дугаар					
27	Хаяг байршил	Аймаг/ хот				
		Сум/дүүрэг				
		Баг/хороо				
		Гудамж, байр				
		Тоот				
28	Холбоо барих утас	Суурин	Гар утас		Факс	
29	Цахим хуудас					
	Цахим шуудангийн хаяг					
	Нийгмийн сүлжээний хаяг					
Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл:						
30	Хувьцаа эзэмшигч \гишүүд\-ийн овог нэр/ оноосон нэр	ХНХ-н хэмжээ (₮)		ХНХ-д эзлэх хувь (%)		
Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл:						
31	Нийт ажилтан, албан хаагчдын тоо _____					
32	Албан тушаал	Овог	Нэр	Регистрийн дугаар	Харьяалал	Мэргэжлийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн эсэх Тийм <input type="checkbox"/> Үгүй <input type="checkbox"/>

Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д нийцүүлэн даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгоно уу.

Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаас хойших хугацаанд Монгол улсын Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, болон бусад холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос өгсөн үүрэг даалгаврыг биелүүлж ажиллах болно.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр _____ албан тушаал _____ гарын үсэг _____ огноо _____
Тамга:

ЗӨВШӨӨРЛИЙН ӨРГӨДӨЛ

1	Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
2	Өргөдөл гаргагчийн оноосон нэр						
3	Регистрийн дугаар						
Зөвшөөрлийн төрлийг сонгоно уу.							
4	<input type="checkbox"/> Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах /5-р хэсгийг бөглөх/ <input type="checkbox"/> Салбар, төлөөлөгчийн газар нээх /6-14-г бөглөх/ <input type="checkbox"/> Оноосон нэр өөрчлөх /15-17-г бөглөх/ <input type="checkbox"/> Даатгагчийн эрх бүхий албан тушаалтан томилох /18-г бөглөх/ <input type="checkbox"/> Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх /19-20-г бөглөх/						
Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах							
5	Оноосон нэр /Овог, нэр	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлтийн дараа	
						ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)
Салбар, төлөөлөгчийн газар нээх							
6	Нэгж байгуулах шийдвэр	Он		Сар		Өдөр	Дугаар
7	Нэгжийн хэлбэр	<input type="checkbox"/> Салбар <input type="checkbox"/> Төлөөлөгчийн газар					
8	Нэгжийн нэр						
9	Хаяг байршил:	Улс					
Аймаг/ хот							
Сум/дүүрэг							
Баг/хороо							
Гудамж, байр							
	Тоот						
10	Холбоо барих утас	Суурин		Гар утас		Факс	
11	Цахим хуудас						
	Цахим шуудангийн хаяг						
12	Нэгжийн нийт ажилтан, албан хаагчдын тоо						
Ашиглах техник тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл							
13	Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан Түрээслэсэн /аль нь болохыг бичих/	Тоо ширхэг	Үнэ ₮		
14	Програм хангамжийн нэр төрөл	Програмын зориулалт	Худалдан авсан Түрээслэсэн /аль нь болохыг бичих/	Тоо ширхэг	Үнэ ₮		

Оноосон нэр өөрчлөх						
15	Даатгалын байгууллагын хуучин нэр					
16	Даатгалын байгууллагын шинэчилсэн нэр					
17	Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан					
Даатгагчийн эрх бүхий албан тушаалтан томилох						
18	Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар
Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх						
19	Албан журмын даатгалын хэлбэрийн нэр					
20	Сонгосон албан журмын даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх шийдвэр			Шийдвэрийн нэр	Огноо	Дугаар

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д нийцүүлэн зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, зөвшөөрлийг олгоно уу.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр албан тушаал гарын үсэг огноо

Тамга:

БҮРТГЭЛИЙН ӨРГӨДӨЛ

1	Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
2	Өргөдөл гаргагчийн оноосон нэр						
3	Регистрийн дугаар						
Бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгоно уу.							
4	<input type="checkbox"/> Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн /5-г бөглөх/ <input type="checkbox"/> Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлт /6-г бөглөх/ <input type="checkbox"/> Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт /7-г бөглөх/ <input type="checkbox"/> Хаягийн өөрчлөлт /8-г бөглөх/						
Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн бүртгүүлэх							
5	№	Даатгалын хэлбэр	Даатгалын бүтээгдэхүүний нэр /Даатгагч бол бөглөх/				
Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийг бүртгүүлэх							
6	Оноосон нэр /Овог, нэр	Регистрийн дугаар	Одоогийн ХНХ хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлтийн дараа ХНХ хэмжээ (₮) ХНХ-д эзлэх хувь (%)	
Эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх							
7	Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	
Хаяг байршилын өөрчлөлтийг бүртгүүлэх							
8		Хуучин хаяг байршил			Шинэ хаяг байршил		
	Нэгжийн нэр						
	Улс						
	Аймаг/ хот						
	Сум/дүүрэг						
	Баг/хороо						
	Гудамж,байр						
	Тоот						
	Холбоо барих утас						

Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн журам”-д нийцүүлэн бүртгэлд шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж, хүргүүлэв. Бүрдүүлсэн баримт бичигт ямар нэг худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг бид хүлээх болно.

Манай өргөдөл, баримт бичгийг хүлээн авч, хянан шийдвэрлэж, бүртгэж өгнө үү.

Өргөдөл гаргасан:

Овог, нэр

албан тушаал

гарын үсэг

огноо

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1	Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр				
2	Хувьцаа эзэмшигч нь <input type="checkbox"/> Хуулийн этгээд /3-15,24-г бөглөх/ <input type="checkbox"/> Иргэн /16-24-г бөглөх/				
Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн мэдээлэл					
2	Хуулийн этгээдийн нэр	Монгол Англи (Хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичих)			
3	Үүсгэн байгуулагдсан огноо	Он	Сар	Өдөр	
4	Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="checkbox"/> Хувьцаат компани <input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани			
5	Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="checkbox"/> Дотоодын хөрөнгө оруулалттай <input type="checkbox"/> Гадаадын хөрөнгө оруулалттай Гадаадын ХО-ын хувь			
6	Улсын бүртгэлийн дугаар				
7	Регистрийн дугаар				
8	Үйл ажиллагааны чиглэл				
9	Хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө ₮				
10	Хаяг байршил	Аймаг/ хот			
		Сум/дүүрэг			
		Баг/хороо			
		Гудамж,байр			
		Тоот			
11	Холбоо барих утас	Суурин	Гар утас	Факс	
11	Цахим хуудас: Цахим шуудангийн хаяг:				
12	Удирдлага	Овог	Нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар
	Гүйцэтгэх захирал				
13	Компанийн нэгдлийн оролцогч эсэх		Тийм <input type="checkbox"/> /14-г бөглөх/	Үгүй <input type="checkbox"/> /14-г бөглөх шаардлагагүй/	
14	Оноосон нэр	Регистрийн дугаар	Үйл ажиллагааны төрөл	Тусгай зөвшөөрөл хүсэгчтэй ямар холбоотой болох	
Хувьцаа эзэмшигч иргэний мэдээлэл					
15	Овог				
16	Нэр				
17	Регистрийн дугаар				
18	Албан ёсны хаяг байршил				
19	Эрхэлж байгаа ажил, албан тушаал				
20	Ажлын хаяг				
21	Эзэмшсэн мэргэжил				
22	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ ₮				
23	Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэр	Эх үүсвэр		Мөнгөн дүн ₮	

(Этгээдийн нэр)..... нь (даатгалын компани, давхар даатгалын компани, зуучлагч компани, хохирол үнэлэгч компани)-ийн хувьцаа эзэмшигч болж, тус компанийн дүрмийн санд оруулж байгаа (үсгээр) төгрөг нь хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанаас олсон цэвэр ашиг, орлогоос бүрдэж байгаа бөгөөд холбогдох материалыг үнэн зөвөөр хууль тогтоомжийн дагуу бүрдүүлэн Хороонд хүргүүлсэн болохоо нотлохын зэрэгцээ үүнээс үүсэх аливаа эрсдэлийг хууль тогтоомжийн дагуу бүрэн хариуцахаа илэрхийлж байна.

Тодорхойлолт гаргасан:

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН
БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1. Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	
Овог нэр:	
Регистрийн дугаар:	
Иргэний харьяалал:	
Эрхлэх албан тушаал:	
Албан тушаалд томилогдсон	Огноо
	Шийдвэрийн нэр
	Шийдвэрийн дугаар
Оршин суугаа газрын хаяг	
Гар утасны дугаар	
Цахим хаяг	
Одоо эрхэлж байгаа ажил	
Албан тушаал	
Ажлын хаяг	
Ажлын цахим хаяг	

Зураг

2. Боловсролын талаар /Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль, сургалтын байгууллага	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он /огноо	Төгссөн он /огноо	Диплом, гэрчилгээ, мэргэшлийн үнэмлэхний дугаар

3. Ажлын туршлагын талаар:

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо	Шалтгаан

4. Эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил	Албан тушаал

Тодорхойлолт гаргасан:

Овог нэр

гарын үсэг

огноо

ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛД
(МАЯГТ СЗХ04001) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудас ны тоо	Албан хэрэгшөөр
1	Компани байгуулах, даатгалын эсхүл даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
3	Компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, компанийн шинэчилсэн дүрмийн төсөл		
4	Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотлох баримт		
5	3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө		
6	Ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар		
7	Жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан / эхлэлтийн тайлан		
8	Хувьцаа эзэмшигч бүрийн СЗХ04005 маягтын дагуу бөглөсөн хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт		
9	СЗХ04006 маягтын дагуу бөглөсөн компанийн эрх бүхий албан тушаалтан болон мэргэжлийн боловсон хүчний тодорхойлолт		
10	Компанийн эрх бүхий албан тушаалтан болон мэргэжлийн боловсон хүчний иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн диплом, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар		
11	Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааварт заасны дагуу бөглөсөн хувь хүн, хуулийн этгээдийн асуулгын хуудас		
12	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1-д заасан дотоод хяналтын хөтөлбөр		
13	Даатгалын байгууллагын боловсон хүчин нь тухайн даатгалын хэлбэрээр мэргэшсэнийг нотлох баримт		
14	Дотоод үйл ажиллагааны журмын төсөл		
Ердийн болон урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд 1-14 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
15	СЗХ04004 маягтын дагуу бөглөсөн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг бүртгүүлэх өргөдөл		
16	Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн тус бүрээр боловсруулсан журам, Иргэний хуулийн 431.4 дэх хэсэгт заасан нөхцөлийг тусгасан даатгалын гэрээ болон гэрээний баталгааны загвар		
17	Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хураамжийн хувь хэмжээ, нөөц сангийн тооцоолол, танилцуулга		
Давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд 1-17 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
18	Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах сангийн мөнгөн хөрөнгийг		

Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд 1-14 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
19	Мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний төсөл		
20	2-оос доошгүй даатгалын компанитай хамтран ажиллах даатгалын зуучлалын гэрээний төсөл		
21	Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх ажилтны даатгалын зуучлагчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт		
Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд өргөдөл гаргагч нь банк бол 1-14, 19-21 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
22	Тус банкыг даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэхэд татгалзахгүй тухай Монгол банкнаас ирүүлсэн баримт бичиг		
23	Даатгалын зуучлалын үйл ажиллагааг хариуцах тусгайлсан нэгжийг байгуулсан буюу томилсон тухай шийдвэрийн хуулбар, тухайн нэгжийн танилцуулга болон банкны бүтэцийг харуулсан бүдүүвч зураг		
24	Хамтран ажиллах даатгагч бүр дээр даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдон гарах гүйлгээ хийгдэх тусдаа данс байхыг нотлох баримт		
Даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөлд 1-14, 19 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
25	Эрхлэх даатгалын хэлбэрийн хохиролын үнэлгээний чиглэлээр үнэлгээчин нь мэргэшсэн гэдгийг нотлох баримт /Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар/		
26	Сонгосон даатгалын хэлбэрээр хохирлын үнэлгээ хийх судалгаа, мэдээллийн сангийн танилцуулга		
27	Даатгалын хохирол үнэлгээ хийх ажилтаны даатгалын хохирол үнэлгээний сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт		

ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ
ХҮССЭН ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04002) БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Баримт бичгийн төрөл		Хуудас ны тоо	Албан хэрэгцээнд
1	Даатгагчтай хамтран ажиллах гэрээний төсөл		
2	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
Өргөдөл гаргагч нь иргэн бол 1-2 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:			
3	Өргөдөл гаргагчийн иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар		
Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол 1-2 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
4	Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр		
5	Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар		
6	Хуулийн этгээдийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, шинэчилсэн дүрмийн төсөл		
	Нийт		

ДААТГАГЧИЙН ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ, ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦЭД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04003)
ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Баримт бичгийн төрөл		Хуудас ны тоо	Хэрэглээнд
1	Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Компанийн шинэчилсэн дүрмийн төсөл		
3	Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотлох баримт /дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх, бүтцэд өөрчлөлт орсон тохиолдолд/		
4	СЗХ04005 маягтын дагуу бөглөсөн шинэ хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт, түүнд хавсаргах баримт бичгүүд /хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд/		
5	Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааварт заасны дагуу хувь хүн, хуулийн этгээдийн бөглөсөн асуулгын хуудас /хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд/		
Нийт			

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН САЛБАР, ТӨЛӨӨЛӨГЧИЙН ГАЗАР НЭЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04003) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Баримт бичгийн төрөл		Хуудас	Анхны
		но.р.оо	хуудасны дугаар
Даатгалын байгууллага нь төлөөлөгчийн газар нээх тохиолдолд дараах 1-4 дугаартай баримт бичгүүдийг бүрдүүлж, зөвшөөрлийн өргөдөлд хавсаргана:			
1	Нэгж нээх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Ажлын байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, эсхүл түрээсийн гэрээний хуулбар		
3	СЗХ04006 маягтын дагуу гаргасан нэгжийн удирдлага, боловсон хүчний тодорхойлолт		
4	Нэгжийн удирдлага болон мэргэжлийн боловсон хүчний иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
Даатгалын байгууллага нь салбар нээх зөвшөөрөл хүссэн тохиолдолд зөвшөөрлийн өргөдөлд 1-4 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
5	Салбар нээхтэй холбоотойгоор өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө		
6	Салбарын дотоод үйл ажиллагааны журмын төсөл		
7	Салбарын удирдлага эсхүл мэргэжлийн боловсон хүчин нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт		
Даатгалын хохирол үнэлэгч салбар нээх зөвшөөрөл хүссэн тохиолдолд зөвшөөрлийн өргөдөлд 1-7 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
8	Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар / эрхлэх даатгалын хэлбэрийн хүрээнд эд хөрөнгөд учирсан бодит хохирлыг тогтоох тохиолдолд/		
Даатгалын компани салбар нээх зөвшөөрөл хүссэн тохиолдолд зөвшөөрлийн өргөдөлд 1-7 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:			
9	Салбарын арилжааны банкин дахь дансны хуулга		
Даатгалын компанийн салбар нь Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 1-7,9 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
10	Салбарын шуурхай албаны бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын шуурхай албаны танилцуулга		
11	Шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний хуулбар		
12	Шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэх тухай гэрээ / шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн тохиолдолд/		
Даатгалын байгууллага нь гадаад улсад салбар нээх зөвшөөрөл хүссэн тохиолдолд зөвшөөрлийн хүсэлтэд 1-7, тусгай зөвшөөрлийн төрлөөс хамааран 8, 9 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
13	Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааврын дагуу бөглөсөн удирдах ажилтны асуулгын хуудас		
Даатгалын байгууллага нь гадаад улсад төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл хүссэн тохиолдолд зөвшөөрлийн хүсэлтэд 1-4, 13 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг			

14	1 өмөөлөгчийн газар нээх үндэслэл, зорилго, үйл ажиллагааны чиглэлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар/төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл хүссэн тохиолдолд	Нийт

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ОНООСОН НЭРИЙГ ӨӨРЧЛӨХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН
ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04003) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудас ны тоо	Албан хэрэглээнд
1	Хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн баталгаажуулалт		
3	Өөрчлөлт оруулсан компанийн дүрэм		
3	Нийт		

ДААТГАГЧИЙН ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН ТОМИЛОХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН
ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04003) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудас ныгтоо	Албан хариуцал
1	Эрх бүхий албан тушаалтныг томилох тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	СЗХ04006 маягтын дагуу гаргасан шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт		
3	Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
4	Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааврын дагуу бөглөсөн шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны асуулгын хуудас		
4	Нийт		

АЛБАН ЖУРМЫН ДААТГАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН
ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04003) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Баримт бичгийн төрөл		Хууль нь тоо	Албан хэрэгшээнд
1	Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбоотойгоор өөрчлөлт оруулсан бизнес төлөвлөгөө		
3	СЗХ04006 маягтын дагуу гаргасан Албан журмын даатгалын тухайн хэлбэрийн үйл ажиллагааг эрхлэх боловсон хүчний тодорхойлолт		
Даатгалын компани нь Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 1-3 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:			
4	Шуурхай албаны бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын шуурхай албаны танилцуулга		
5	Шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний хуулбар		
6	Шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэх тухай гэрээ / шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн тохиолдолд/		
Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаанаас бусад албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд 1-3 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгийг хавсаргана:			
7	Хууль тогтоомжид заасан бусад шаардлагатай баримт бичиг		
	Нийт		

ДААТГАЛЫН ХЭЛБЭР, БҮТЭЭГДЭХҮҮН БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛД
(МАЯГТ СЗХ04004) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

№	Баримт бичгийн төрөл	Хуудас ны тоо	Албан хэрэгцээнд
Даатгалын мэргэжлийн оролцогч эрхлэх даатгалын хэлбэрийг бүртгүүлэхэд 1-3 дугаартай баримт бичгүүдийг хавсаргана:			
1	Тухайн даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Даатгалын байгууллагын боловсон хүчин нь тухайн даатгалын хэлбэрээр мэргэшсэнийг нотлох баримт, СЗХ04006 маягтын дагуу гаргасан боловсон хүчний тодорхойлолт		
3	Бүртгүүлэх даатгалын хэлбэртэй холбогдуулан өөрчилсөн бизнес төлөвлөгөө		
Даатгалын компани эрхлэх даатгалын хэлбэрийг бүртгүүлэх тохиолдолд 1-3 дугаартай баримт бичгүүдээс гадна дараах баримт бичгүүдийг хавсаргана:			
4	Даатгалын бүтээгдэхүүний судалгаа, танилцуулга		
5	Иргэний хуулийн 431.4 дэх хэсэгт заасан нөхцөлийг тусгасан даатгалын бүтээгдэхүүний гэрээний болон баталгааны загвар		
6	Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний журам		
7	Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хураамжийн хувь хэмжээ, нөөц сангийн тооцоолол, танилцуулга		
Даатгалын компани даатгалын бүтээгдэхүүнийг бүртгүүлэх тохиолдолд 4-7 дугаартай баримт бичгүүдийг хавсаргана.			
	Нийт		

ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛД
(МАЯГТ СЗХ04004) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

Баримт бичгийн төрөл		Хуудас нэгтгөө	Хуудас хэрэглэсэн
1	Эрх бүхий албан тушаалтныг томилох тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн дипломын хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар		
3	Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааврын дагуу бөглөсөн шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны асуулгын хуудас		
4	СЗХ04006 маягтын дагуу гаргасан шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт		
4	Нийт		

ДААТГАЛЫН ЗУУЧЛАГЧ, ХОХИРОЛ ҮНЭЛЭГЧИЙН ДҮРМИЙН САНГИЙН ХЭМЖЭЭ,
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ
ӨРГӨДӨЛД (МАЯГТ СЗХ04004) ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ

	Баримт бичгийн төрөл	Хуудас ны тоо	Албан хэрэгшэнд
1	Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэр		
2	Компанийн шинэчилсэн дүрмийн төсөл		
3	Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг хууль ёсны орлогоос бүрдсэнийг нотлох баримт /дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх, бүтцэд өөрчлөлт орсон тохиолдолд/		
4	СЗХ04005 маягтын дагуу бөглөсөн шинэ хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт, түүнд хавсаргах баримт бичгүүд		
5	Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааварт заасны дагуу хувь хүн, хуулийн этгээдийн бөглөсөн асуулгын хуудас /хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд/		
	Нийт		



МОНГОЛ УЛСЫН

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны ____ оны ____ сарын ____ өдрийн ____ дугаар тогтоолоор
_____-д

____ үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

"Тэмдэг"

Энэ гэрчилгээ нь
хавсралтын хамт
хүчинтэй.



МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

_____ ТООТ

ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

"Тэмдэг"

Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчид
зориулсан тэмдэглэлүүд

Энэ хавсралт нь тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хамт хүчинтэй.

ПЭЛ. ДААТГАЛЫН БАИГУУЛЛАГЫН ОНООСОН НЭР. _____

ХОЁР. Тусгай зөвшөөрлийн төрөл: _____

ГУРАВ. Эрхлэх даатгалын ангилал: _____


ДӨРӨВ. Эрхлэх даатгалын хэлбэрийн талаарх тэмдэглэл:

[illegible]

ТАВ. Тусгай зөвшөөрлийн тэмдэглэл:

№	Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тэмдэглэл	Тогтоолын огноо	Тогтоолын дугаар	Тэмдэглэл хийсэн огноо, тэмдэг

[illegible]



ДААТГАЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИЙН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар

3*4
хэмжээтэй
Зураг

“ТЭМДЭГ”

_____ХХК-ийн даатгалын
төлөөлөгчөөр ажиллах тусгай зөвшөөрөл олгов.

Санхүүгийн зохицуулах хорооны Ажлын албаны дарга
Б.Батсэлэнгэ

Олгосон огноо _____ - _____ - _____

“Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн
үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл,
бүртгэлийн журам”-ын 4 дүгээр хавсралт

Эрхлэх даатгалын хэлбэрийн талаарх тэмдэглэл:

[illegible]



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН НЭГЖИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар ...


... оны ... сарын ... өдөр

Монгол Улсын Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль, Даатгалын хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын _____ оны ____ сарын ____ өдрийн _____ дугаар тушаалаар _____ оноосон нэр бүхий Даатгалын байгууллагад _____ улсын _____ хот/аймгийн _____ дүүрэг/сум/-нд _____ нээн ажиллуулахыг зөвшөөрч, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тэмдэг”

**ДААТГАЛЫН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРЛОЦОГЧИЙН ҮЙЛ
АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ, БҮРТГЭЛИЙН
МАЯГТЫГ БӨГЛӨХ, БАРИМТ БИЧГИЙГ БҮРДҮҮЛЭХ ЗААВАР**



Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү зааврын зорилго нь даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягтыг бөглөх, тэдгээрт хавсаргах баримт бичигт тавигдах шаардлагыг тодорхойлоход оршино.

1.2. Тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягтыг Санхүүгийн зохицуулах хороо /цаашид "Хороо" гэх/-ны цахим хуудас дахь (www.frc.mn) "цахим" өргөдлийн маягт цонхонд хандаж бөглөнө. Өргөдлийн маягтыг цаасан хэлбэрээр бөглөхдөө Хорооны цахим хуудаснаас маягтыг татаж авна.

1.3. Маягтыг бөглөхдөө техникийн үзүүлэлт, компанийн хэлбэрээс бусад тохиолдолд товчлол хэрэглэхгүй, овог нэр, оноосон нэр, он сар өдрийг бүтэн бичиж, хариулт сонголттой тохиолдолд тохирох нүдэнд “√” тэмдгийг тавина.

1.4. Гадаад улсад үүсгэн байгуулагдсан /гадаад улсад бүртгэлтэй/ хуулийн этгээдийн оноосон нэрийг түүний албан ёсны латин үсгээр бичигдсэн нэр болон Монгол үсгээр галиглан бичсэн нэрээр, регистрийн дугаарыг тухайн улсын бүртгэлийн албанаас олгосон бүртгэлийн дугаараар бичнэ.

1.5. Гадаад улсын иргэний талаарх мэдээллийг оруулахдаа овог нэрийг латин үсгээр бичиж, регистрийн дугаар хэсэгт гадаад паспортын дугаарыг бөглөнө.

1.6. Маягтыг бөглөхдөө шаардлагатай тохиолдолд хүснэгтийн тохирох хэсэгт үндсэн маягтын бүтцийн хүрээнд мөр, багана нэмж болно.

1.7. Маягтад дурдсан мэдээлэл тус бүрийн мөрийн дугаар болон хавсаргах баримт бичгийн жагсаалт дахь харгалзах дугаарын дагуу зааварчилгааг тусгасан болно.

1.8. Өргөдөл, тодорхойлолт гаргагч нь хуулийн этгээд бол тухайн өргөдөл, тодорхойлолт гаргагчийн эрх бүхий албан тушаалтан өргөдөл, тодорхойлолтод овог нэр, албан тушаал, өргөдөл, тодорхойлолт гаргасан огноог бичиж, гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулна. Иргэн бол өөрийн овог нэр, өргөдөл, тодорхойлолт гаргасан огноог бичиж, гарын үсэг зурж баталгаажуулна.

1.9. Өргөдөл, тодорхойлолтын маягтад гадаад валютыг өргөдөл, тодорхойлолт гаргаж буй өдрийн Монголбанкны албан ханшаар төгрөгт шилжүүлэн илэрхийлнэ.

1.10. Бизнес төлөвлөгөөг энэ зааврын 1 дүгээр хавсралт “Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж”-ийн дагуу, дотоод үйл ажиллагааны журмыг энэ зааврын 2 дугаар хавсралт “Дотоод үйл ажиллагааны журам боловсруулах зөвлөмж”-ийн дагуу, эхлэлтийн тайланг энэ зааврын 3 дугаар хавсралтын дагуу тус тус гаргана.

Хоёр. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн маягтыг бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх

2.1. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04001 маягтыг бөглөх, түүнд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх

2.1.1. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04001 маягтыг бөглөх

Тусгай зөвшөөрлийн төрөл, хэлбэрийн мэдээлэл

- 1) Өргөдөл гаргасан огноо: Он, сар өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.
- 2) Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн нэр: Үүсгэн байгуулагдсан хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.
- 3) Өмнө нь санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийж 5 дугаар мөр лүү шилжинэ.

- 5) Өмнө нь Хороонд даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл ирүүлж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийж, 8 дугаар мөр лүү шилжинэ.
- 6) 5 дугаар мөрөнд тийм гэсэн хариултыг сонгосон бол 6 дугаар мөрөнд өмнө нь хүсэлт ирүүлж байсан тусгай зөвшөөрлийн төрлийг бичнэ.
- 7) 7 дугаар мөрөнд тусгай зөвшөөрөл олгогдсон эсэхээс хамааран тохирох сонголтыг хийнэ.
- 8) Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгоно. Үйл ажиллагааны төрлийг сонгохын өмнө Даатгалын тухай хуулийн 20.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 12 дугаар зүйлтэй уншиж танилцана уу.
- 9) Ердийн даатгалын үйл ажиллагаа эрхлэхээр сонгосон бол 9 дүгээр мөрөөс эрхлэх даатгалын хэлбэрийг сонгоно.
- 10) Урт хугацааны даатгалын үйл ажиллагаа эрхлэхээр сонгосон бол 10 дугаар мөрөөс эрхлэх даатгалын хэлбэрийг сонгоно.
- 11) Даатгалын мэргэжлийн оролцогч нь эрхлэх үйл ажиллагааны төрлийг сонгосны дараа 9, 10, 11 дугаартай мөрүүдээс эрхлэх даатгалын хэлбэрийг сонгоно.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

- 12) Оноосон нэр: Монгол – хуулийн этгээдийн нэрийг кирилл үсгээр, бүтэн бичнэ.
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.
- 13) Хэрэв хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдөж байсан бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он, сар, өдөр гэсэн дарааллаар бичих
- 14) Хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан хурлын огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.
- 15) Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцаат компани, ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.
- 16) Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгож, гадаадын хөрөнгө оруулалттай бол нийт хувьцааны хэдэн хувийг гадаадын хөрөнгө оруулагч
*Дотоодын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт хувьцааг /100 хувь/ Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд эзэмшдэг,
Гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг тус тус ойлгоно.*
- 17) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.
- 18) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.
- 19) Хаяг байршил: Хуулийн этгээдийн одоо байршиж байгаа эсхүл байршихаар гэрээ байгуулсан байрны хаягийг хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй бичнэ.
- 20) Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсын дугаарыг бичнэ.
- 21) Цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хуудсыг бичнэ. Цахим шуудангийн хаяг: Хуулийн этгээдийн цахим шуудангийн хаягийг бичнэ.
Нийгмийн сүлжээний хаяг: www.twitter.com, www.facebook.com гэх мэт олон нийтийн сүлжээн дэх хаягийг бичнэ.

Банкин дахь харилцах, хадгаламжийн мэдээлэл

- 22) Дансны төрлийг сонгож, банкны нэр, дансны дугаар, дансны валютын төрлийг бичиж, холбогдох дансны үлдэгдлийг тухайн өдрийн Монголбанкны албан ханшаар тооцон төгрөгөөр илэрхийлнэ.

23) Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч бүрээр хүснэгт дэх мэдээллийг оёглөнө.

-Хувьцаа эзэмшигчдийн овог нэр/ оноосон нэр хэсэгт хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол түүний оноосон нэрийг, иргэн бол иргэний овог нэрийг бичнэ.

-Хувьцааны тоо хэсэгт тухайн хувьцаа эзэмшигчийн нийт эзэмшиж буй хувьцааны тоог бичиж, хувьцааны төрлүүдээс сонголтыг хийнэ.

-ХНХ-н хэмжээ хэсэгт тухайн хувьцаа эзэмшигчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн, дараагийн хэсэгт энэхүү хөрөнгө нь нийт хувь нийлүүлсэн хөрөнгийн хичнээн хувийг бүрдүүлж байгааг зуутын орны /таслалаас хойш 2 орны/ нарийвчлалтайгаар тусгана. /Жишээ нь 50.85 %/

24) Компанийн тухай хуулийн 6.13-т заасан компанийн нэгдлийн оролцогч биш бол үгүй гэсэн хариултыг сонгон 26 дугаар мөр лүү шилжинэ.

25) 24 дүгээр мөрөнд тийм гэсэн хариултыг сонгосон бол 25 дугаар мөрөнд компанийн нэгдлийн оролцогч бүрийн оноосон нэрийг хуулийн этгээдийн хэлбэрийн хамт оноосон нэр хэсэгт бичиж, регистрийн дугаар, үйл ажиллагааны төрлийг бичнэ.

-Тусгай зөвшөөрөл хүсэгчтэй ямар холбоотой болох хэсэгт толгой компани, хараат компани, охин компани, зэргэлдээ компани, үүнээс ч илүү үргэлжилсэн хэлхээ холбоонд компанийн нэгдлийн оролцогч гэж бичнэ.

Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл

26) Төлөөлөн удирдах зөвлөлтэй байх бол тийм гэсэн хариултыг сонгон, зөвлөлийн бүрэлдэхүүний тоог бичнэ. Үгүй гэсэн хариултыг сонгосон бол 27 дугаар мөр лүү шилжинэ.

27) Дотоод хяналтын нэгжтэй байх бол тийм гэсэн хариултыг сонгон, нэгжийн бүрэлдэхүүний тоог бичнэ. Үгүй гэсэн хариултыг сонгосон бол 28 дугаар мөр лүү шилжинэ.

28) Нийт ажилтан албан хаагчдын тоо хэсэгт хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллах болон ажиллаж буй нийт ажилтны тоог бичнэ.

29) Даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол даатгалын андеррайтер, актуарч, даатгалын борлуулалт болон нөхөн төлбөр хариуцсан ажилтан, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх бол даатгалын зуучлалын борлуулалтын ажилтан, даатгалын хохирол үнэлэгчийн үйл ажиллагаа эрхлэх бол хөрөнгийн үнэлгээчин гэх мэт мэргэжлийн боловсон хүчний тоог нэгтгэн гаргаж даатгалын мэргэжлийн боловсон хүчний тоо мөрөнд бичих бөгөөд даатгалын үйл ажиллагаа эрхлэх бол даатгалын актуарчийн тоог бичнэ.

30) Ажлын байрны мэдээлэл хэсэгт тухайн ажлын байрыг худалдаж авсан, түрээслэсэн аль нь болохыг сонгоно.

Ашиглах техник, тоног төхөөрөмж, програм хангамжийн мэдээлэл

31) Үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжийг нэр, төрөл бүрээр түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэг, үнийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу нөхөх ба тухайн тоног төхөөрөмжийг худалдаж авсан түрээслэсэн аль нь болохыг сонгоно. Тоног төхөөрөмжийн үнэ нь худалдан авсан өртөг байна.

32) Програм хангамжийн зориулалт баганад тухайн програмыг ямар зориулалтаар ашиглах талаар бичнэ. Жишээ нь: нягтлан бодох бүртгэл, даатгалын мэдээллийн санд мэдээ өгч, авах, өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулах гэх мэт.

Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн төлөвлөлт

33) Компанийн нийт хөрөнгө, хувь нийлүүлсэн хөрөнгө, нийт орлого, зардал, цэвэр ашгийн хэмжээг тооцон, дараалсан 3 жилээр тухайн оны дүнг төгрөгөөр илэрхийлэн бичих бөгөөд энэ нь бизнес төлөвлөгөөнд тусгагдсантай ижил байна.

34) Даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн бол 33, 34 дүгээр мөрөнд үзүүлэлтүүдийг бөглөнө. “Хохирол нөхөлтийн харьцаа” үзүүлэлтээс бусад

2.1.2. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04001 маягтын дагуу гаргасан өргөдөлд хавсаргах баримт бичигт тавигдах шаардлага

1. Нэгээс дээш үүсгэн байгуулагч нийлж компанийг байгуулж байгаа бол компани байгуулж, холбогдох тусгай зөвшөөрөл хүссэн үйл ажиллагаа эрхлэх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр эсхүл Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолын эх хувь, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, нэг үүсгэн байгуулагчтай бол компани үүсгэн байгуулах шийдвэр, эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
2. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, түүний хавсралтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
3. Улсын бүртгэлийн албанд бүртгүүлсэн компанийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар
4. Компанийн дүрмийн санд хувьцаа эзэмшигч нарын оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь хууль ёсны орлогоос бүрдсэн болохыг нотлох баримт бичиг. Хэрвээ баримт бичгийн эх хувийг хавсаргах боломжгүй бол нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана. /Ногдол ашиг хуваарилсан талаарх шийдвэр, төлбөрийн баримт, дансны хуулга, худалдаж худалдан авах гэрээ, бэлэглэлийн гэрээ, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар, хадгаламжийн дэвтрийн хуулбар, зээлийн гэрээний хуулбар гэх мэт/
5. Энэ зааврын 1 дүгээр хавсралт “Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж”-ийн дагуу гаргасан 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө.
6. Ажлын байрыг худалдан авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, түрээслэсэн бол түрээсийн гэрээний хуулбар.
7. Тусгай зөвшөөрлийн өргөдөл гаргахаас өмнө 1 жилээс доошгүй хугацаагаар үйл ажиллагаа эрхэлж байсан бол жилийн эцсийн аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан, үйл ажиллагаа эрхэлж байгаагүй бол эхлэлтийн тайлан.
8. Өргөдөл гаргагчийн нийт энгийн хувьцааны 10 ба түүнээс дээш хувийг дангаараа болон бусад этгээдтэй хамтран эзэмшдэг этгээд бүр энэ зааврын дагуу маягт СЗХ04005-г бөглөж, хувьцаа эзэмшигчийн тодорхойлолтыг гаргана. Тодорхойлолтод хувьцаа эзэмшигчийн иргэний цахим үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ), эрхэлж буй ажил, албан тушаалыг нотлох баримтыг хавсаргана. (тухайлбал нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт...).
9. Энэ зааврын дагуу маягт СЗХ04006-г өргөдөл гаргагчийн эрх бүхий албан тушаалтан болон мэргэжлийн боловсон хүчин бүр бөглөж, эрх бүхий албан тушаалтан болон боловсон хүчний тодорхойлолтыг гаргана. Компанийн эрх бүхий албан тушаалтан гэдэгт 84.1-т заасан буюу компанийн дүрэмд заасан эрх бүхий албан тушаалтныг ойлгоно.
10. Компанийн эрх бүхий албан тушаалтан болон мэргэжлийн /даатгалын борлуулалтын ажилтан, даатгалын менежер, даатгалын нөхөн төлбөрийн ахлах ажилтан, даатгалын актуарч, даатгалын андеррайтер гэх мэт/ боловсон хүчний иргэний үнэмлэхний гэрчлүүлсэн хуулбар. Тэдгээрийн мэргэжлийн /даатгал, санхүү, эдийн засаг болон бусад/ диплом, мэргэшлийн үнэмлэх, гэрчилгээ мөн нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар болон даатгалын байгууллагад ажиллаж байсан бол тус байгууллагын гаргасан тодорхойлолт.
11. Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааврын 1.2-т заасан этгээд бүр бөглөсөн тус зааврын хавсралтаар батлагдсан асуулгын хуудас.
12. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу боловсруулсан дотоод хяналтын хөтөлбөр буюу:
 - сэжигтэй гүйлгээг илрүүлэх, мэдээллийн нууцлалыг хадгалах, Санхүүгийн мэдээллийн алба болон эрх бүхий бусад байгууллагад мэдээлэл өгөх, баримт бичиг шилжүүлэх журам;
 - мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль тогтоомж болон дээрх журмын хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилох, чөлөөлөх журам, түүний эрх, үүрэг;

санхүүжүүлэх эрсдэлийг үнэлж, өндөр эрсдэлтэй харилцагч, үйлчилгээ, бүтээгдэхүүнийг онцгой анхаарахад чиглэсэн арга хэмжээний цогц хөтөлбөр.

Дотоод хяналтын хөтөлбөрийг боловсруулахдаа Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2011 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 156/45 тоот хамтарсан тушаалаар батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд хяналт шалгалт хийх журам”-тай сайтар танилцсан байвал зохино.

13. Эрхлэх даатгалын хэлбэрээр мэргэшсэн буюу өмнө нь даатгалын байгууллагад тухайн даатгалын хэлбэрийн даатгалын бүтээгдэхүүнтэй холбогдох үйл ажиллагааг хариуцан 1-ээс доошгүй жил ажилласан /даатгалын байгууллагын чиглэлээс хамааран даатгалын гэрээг байгуулах, борлуулах, тухайн даатгалын хэлбэрийн хохирлын үнэлгээг хийх гэх мэт/ эсхүл тухайн даатгалын хэлбэрийн болон хөтөлбөрт нь тус даатгалын хэлбэрийн талаарх хичээл багтсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт.
14. Энэ зааврын 2 дугаар хавсралт “Дотоод үйл ажиллагааны журам боловсруулах зөвлөмж”-ийн дагуу гаргасан дотоод үйл ажиллагааны журмын төсөл.
15. Энэ зааварт заасны дагуу СЗХ04004 маягтаар гаргасан даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн бүртгүүлэх өргөдлийг гаргана.
16. Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний журам: Тухайн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнтэй холбоотойгоор даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журам, заавар;
-Даатгалын гэрээ, баталгааны загвар: Иргэний хуулийн 431.4 дэх хэсэгт заасан нөхцөлийг тусгасан, Даатгалын тухай хууль болон даатгалын багц дүрмээр тавигдсан шаардлагыг хангасан даатгалын бүтээгдэхүүний гэрээний болон баталгааны загвар;
17. Даатгалын хэлбэрт хамаарах бүтээгдэхүүн тус бүрийн хураамжийн хувь хэмжээ, нөөц сангийн тооцоолол, танилцуулга: Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд даатгалын хураамжийн хэмжээг тооцоолохдоо ашигласан тоон мэдээлэл, аргачлал, эрсдэл тус бүрийн түвшин, хувь хэмжээ, түүнийг тооцоолсон аргачлал, цэвэр хураамжийн хувь, нийт хураамжийн хувийн талаарх мэдээллийг агуулсан актуарын тайлан, танилцуулга.
18. Хорооноос баталсан Давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах санг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журамд заасан хэмжээгээр давхар даатгагчийн алдагдлаас хамгаалах сангийн мөнгөн хөрөнгийг Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан, Компанийн тухай хуулийн 99.1-д заасан компанийн нэгдмэл сонирхолтой этгээдэд хамаарах банкнаас бусад банкинд байршуулсан дансны хуулга.
19. Хууль тогтоомжид заасан мэргэжлийн хариуцлагын доод хэмжээний хязгаараас багагүй хэмжээний даатгалын үнэлгээтэй мэргэжлийн хариуцлагын даатгалын гэрээний төсөл. Гэрээний төсөлд гэрээнд оролцогч талууд гарын үсэг зурж, тамга дарсан байна.
20. Хоёроос доошгүй даатгалын компанитай байгуулах хамтран ажиллах гэрээний төсөл. Хамтран ажиллах гэрээний төсөлд дараах зүйлийг тусгана:
-Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 26.1 дэх хэсэгт заасны дагуу даатгалын хураамжийн орлогыг даатгагчийн дансанд шуурхай шилжүүлэх ажиллагааны зохицуулалт;
-хамтран ажиллах даатгагч бүрийн нэр дээр данс нээх талаарх зохицуулалт; /Хэрвээ банк бол/
-даатгалын хураамж төлөгдсөнөөр даатгалын гэрээ байгуулагдсанд тооцож, даатгалын тохиолдол гарахад даатгалын хураамжийн орлого даатгагчийн дансанд шилжсэн эсэхээс үл хамааран даатгагч даатгуулагчид нөхөн төлбөр олгох талаарх зохицуулалт;
21. Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх ажилтан нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоотой хамтран зохион байгуулсан зохион байгуулсан даатгалын зуучлалын сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт.

бичиг.

23. Даатгалын зуучлалын үйл ажиллагааг хариуцах тусгайлсан нэгжийг байгуулсан буюу томилсон тухай шийдвэрийн хуулбар, тухайн нэгжийн танилцуулга болон банкны бүтэцийг харуулсан бүдүүвч зураг.
24. Хамтран ажиллах даатгагч бүр дээр даатгалын зуучлалын үйл ажиллагаатай холбогдон гарах гүйлгээ хийгдэх данс нээснийг нотлох дансны хуулга, хамтын ажиллагааны гэрээнд тусгасан байдал
25. Эрхлэх даатгалын хэлбэрийн хохирлын үнэлгээний чиглэлээр үнэлгээчин нь мэргэшсэн гэдгийг нотлох баримт – тухайн даатгалын хэлбэр, түүний хохирлын үнэлгээний талаар сургалтад хамрагдсан, тухайн чиглэлээр үнэлгээ хийх эрх, зөвшөөрлийг төрийн эрх бүхий байгууллагаас авсан баримт бичиг, тухайн хэлбэрийн хохирлын үнэлгээгээр ажиллаж байсан туршлагатайг нотлох баримт. Эрхлэх даатгалын хэлбэрээс хамааран эд хөрөнгийн хохирлыг үнэлэх тохиолдолд Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
26. Сонгосон даатгалын хэлбэрээр хохирол үнэлгээ хийж гүйцэтгэхэд шаардлагатай судалгааны материал, програм хангамж, мэдээллийн сангийн танилцуулга.
27. Даатгалын хохирол үнэлгээ хийх ажилтны Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын хохирол үнэлгээний сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт.

2.2. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04002 маягтыг бөглөх, түүнд хавсаргах баримт бичгийг бүрдүүлэх.

2.2.1. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04002 маягтыг бөглөх

Эрхлэх үйл ажиллагааны мэдээлэл

- 1) Өргөдөл гаргасан огноо: Он, сар өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.
- 2) Өргөдөл гаргагчийн овог нэр, оноосон нэр: Өргөдөл гаргагч нь иргэн бол овог нэрийг, хуулийн этгээд бол оноосон нэрийг бичнэ.
- 3) Өмнө нь өргөдөл гаргагч хуулийн этгээд нь санхүүгийн салбарт ажиллаж байгаагүй /хуулийн этгээд бол санхүүгийн салбарт үйл ажиллагаа явуулж байгаагүй/ бол үгүй гэсэн сонголтыг хийж 5 дугаар мөр лүү шилжинэ.
- 4) 3 дугаарт тийм гэсэн хариултыг сонгосон бол 4 дүгээр мөрөнд эрхэлж байсан үйл ажиллагааны төрлийг бичнэ.
- 5) Өмнө нь Хороонд даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн өргөдөл ирүүлж байгаагүй бол үгүй гэсэн сонголтыг хийж, 8 дугаар мөр лүү шилжинэ.
- 6) 5 дугаарт тийм гэсэн хариултыг сонгосон бол 6 дугаар мөрөнд хүсэлт ирүүлж байсан тусгай зөвшөөрлийн төрлийг бичнэ.
- 7) 7 дугаар мөрөнд тусгай зөвшөөрөл олгогдсон эсэхээс хамааран тохирох сонголтыг хийнэ.
- 8) Тусгай зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааны хэлбэрийг сонгоно.
- 9) Өргөдөл гаргач нь тохирох сонголтыг хийж, иргэн 10-19 дүгээр мөрийг бөглөнө. Хуулийн этгээд бол 20-32 дугаар мөрийг бөглөнө.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх иргэний мэдээлэл

- 10) Өргөдөл гаргагч иргэний овог буюу иргэний цахим үнэмлэх дээрх эцэг/эх/-ийн нэрийг бичнэ.
- 11) Өргөдөл гаргач иргэн өөрийн нэрийг бичнэ.
- 12) Өргөдөл гаргагч иргэн өөрийн регистрийн дугаарыг бичнэ.
- 13) Өргөдөл гаргагч иргэн өөрийн оршин суугаа газрын хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр, тоот гэсэн дарааллаар бичнэ.

- 15) Ажил эрхэлдэг бол ажлын газрын хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр, тоот гэсэн дарааллаар бичнэ.
- 16) Өргөдөл гаргагч иргэн нь мэргэжил эзэмшсэн бол эзэмшсэн мэргэжлийн нэрийг бичнэ.
- 17) Өргөдөл гаргагч иргэнтэй холбоо барих утасны дугаарыг бичнэ.
- 18) Өргөдөл гаргагчийн цахим шуудангийн хаягийг бичнэ.
- 19) Өргөдөл гаргагч иргэн нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж шалгалтад тэнцсэн бол тийм гэсэн сонголтыг хийж, үгүй бол үгүй гэсэн сонголтыг хийнэ.

Тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн мэдээлэл

- 20) Оноосон нэр: Монгол – хуулийн этгээдийн нэрийг кирилл үсгээр, бүтэн бичнэ.
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.
- 21) Хэрэв хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдөж байсан бол өмнөх нэрийг бүтэн бичиж, хэзээнээс хэдий хүртэл тухайн нэр ашиглагдсан талаарх хугацааг он, сар, өдөр гэсэн дарааллаар бичих
- 22) Хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан хурлын огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.
- 23) Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцаат компани, ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.
- 24) Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгож, гадаадын хөрөнгө оруулалттай бол нийт хувьцааны хэдэн хувийг гадаадын хөрөнгө оруулагч *Дотоодын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт хувьцааг /100 хувь/ Монгол улсын иргэн, Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд эзэмшдэг, Гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг тус тус ойлгоно.*
- 25) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.
- 26) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.
- 27) Хаяг байршил: Хуулийн этгээдийн одоо байршиж байгаа эсхүл байршихаар гэрээ байгуулсан байрны хаягийг хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй бичнэ.
- 28) Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсны дугаарыг бичнэ.
- 29) Цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хуудсыг бичнэ. Цахим хуудасгүй бол нөхөх шаардлагагүй.
Цахим шуудангийн хаяг: Хуулийн этгээдийн цахим шуудангийн хаягийг бичнэ.
Нийгмийн сүлжээний хаяг: www.twitter.com, www.facebook.com гэх мэт олон нийтийн сүлжээн дэх хаягийг бичнэ.

Хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл

- 30) Хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч /гишүүн/-ийн овог нэр / оноосон нэрийг бичиж, тухайн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн, нийт хувь нийлүүлсэн хөрөнгөд түүний хувь нийлүүлсэн хөрөнгийн эзлэх хувийг бичнэ. Эдгээр мэдээллийг хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч бүр бөглөнө.

Удирдлага боловсон хүчинтэй холбоотой мэдээлэл

- 31) Хуулийн этгээдтэй хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллаж буй нийт ажилтны тоог бичнэ.

дугаар, иргэний харьяалалыг бичиж, Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэн эсэх тохирох хариултыг сонгоно.

1.2.2. Тусгай зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04002 маягтын дагуу гаргасан өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Даатгалын төлөөлөгчийн шимтгэл олгох нөхцлийг хууль тогтоомжид нийцүүлэн тусгасан даатгагчтай хамтран ажиллах бичгээр байгуулсан гэрээ.
2. Даатгалын төлөөлөгчөөр ажиллах этгээдийн Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын төлөөлөгчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт, мөн ажил эрхэлдэг бол тухайн этгээдийн нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
3. Өргөдөл гаргагч нь иргэн бол иргэний цахим үнэмлэх болон мэргэжил эзэмшсэн бол тухайн мэргэжлийн диплом, гэрчилгээний хуулбар.
4. Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагаа эрхлэх тухай хуулийн этгээдийн эрх бүхий этгээдийн шийдвэр.
5. Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар.
6. Өргөдөл гаргагч нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн дүрмийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, шинэчилсэн дүрмийн төсөл.

Гурав. Зөвшөөрлийн өргөдлийн маягтыг бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх

3.1.Зөвшөөрлийн өргөдлийн СЗХ04003 маягтыг бөглөх

- 1) Өргөдөл гаргасан огноо: Он, сар, өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.
- 2) Өргөдөл гаргагч даатгалын байгууллагын нэр: Даатгалын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.
- 3) Регистрийн дугаар: Даатгалын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.
- 4) Зөвшөөрлийн төрлийг сонгох: Маягтад дурдсан 5 төрлөөс зөвшөөрлийн хүсэлт гаргаж буй төрлийг сонгох бөгөөд сонгосон төрөлтэй холбогдуулан дараах байдлаар мэдээллийг бөглөнө.
 - “Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 5 дугаар мөрийг бөглөнө.
 - “Салбар, төлөөлөгчийн газар нээх” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 6-14 дүгээр мөрийг бөглөнө.
 - “Оноосон нэр өөрчлөх” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 15-17 дугаар мөрийг бөглөнө.
 - “Даатгагчийн эрх бүхий албан тушаалтан томилох” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 18 дугаар мөрийг бөглөнө.
 - “Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 19-20 дугаар мөрийг бөглөнө.

Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах

- 5) Даатгагчийн өмнөх болон шинэ хувьцаа эзэмшигч тус бүрийн хувьд мэдээллийг дараах байдлаар бөглөнө.
 - Хувьцаа эзэмшигч: Хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний цахим үнэмлэх дэх овог нэр, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.

регисрийн дугаарыг бичнэ.

- Одоогийн ХНХ хэмжээ: Хороонд бүртгүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигч тус бүрээр төгрөгөөр илэрхийлж бичнэ.

- Нэмэгдсэн: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж байгаа тохиолдолд нэмэгдүүлж буй дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

- Хасагдсан: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ бууруулж байгаа тохиолдолд бууруулж буй дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

- Өөрчлөлтийн дараа ХНХ хэмжээ: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээн дээр нэмэгдүүлж буй дүнг нэмээд, бууруулж буй дүнг хасаад гарсан дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

- Өөрчлөлтийн дараа ХНХ-д эзлэх хувь: Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орсны дараагаар дүрмийн санд хувьцаа эзэмшигч тус бүрийн эзлэх хувийг гаргаж бичнэ. (Нийт дүрмийн санг 100% гэж үзнэ)

Салбар төлөөлөгчийн газар нээх

- 6) Даатгалын байгууллагын нэгж байгуулах буюу тухайн нэгжээр дамжуулан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх нэгж нээх тухай шийдвэр гарсан огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар шийдвэрийн дугаарын хамт тохирох нүдэнд бичнэ.
- 7) Нэгжийн хэлбэр буюу салбар, төлөөлөгчийн газрын аль нь болохыг сонгоно.
- 8) Нэгжийн нэр буюу тухайн салбар эсхүл төлөөлөгчийн газрын нэр.
- 9) Нэгжийн ажлын байрыг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээн дэх хаяг, түрээслэсэн бол түрээсийн гэрээн дэх хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж, байр, тоот гэсэн дарааллаар бүрэн гүйцэт бичнэ.
- 10) Холбоо барих утас: Тухайн нэгжийн ашиглаж буй суурин утас, факс болон холбогдох албан тушаалтны утсыг бичнэ.
- 11) Тухайн нэгжийн цахим хуудас, цахим шуудангийн хаягийг бичнэ.
- 12) Компанийн удирдлагаас тухайн нэгжийн ажилтнаар томилсон нийт ажилтны тоог бичнэ.
- 13) Үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжийг нэр, төрөл бүрээр түүний хүчин чадал, багтаамж, тоо ширхэг, үнийн талаарх мэдээллийг хүснэгт дэх асуулгын дагуу нөхөх ба тухайн тоног төхөөрөмжийг худалдаж авсан түрээслэсэн аль нь болохыг сонгоно. Тоног төхөөрөмжийн үнэ нь худалдан авсан өртөг байна.
- 14) Програм хангамжийн зориулалт баганад тухайн програмыг ямар зориулалтаар ашиглах талаар бичнэ. Жишээ нь нягтлан бодох бүртгэл, даатгалын мэдээллийн санд мэдээ өгч, авах, өдөр тутмын мэдээ, мэдээлэл боловсруулах гэх мэт.

Оноосон нэр өөрчлөх

- 15) Даатгалын байгууллагын хуучи оноосон нэрийг бичнэ.
- 16) Даатгалын байгууллагын шинэ оноосон нэрийг бичнэ.
- 17) Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгааныг товч, тодорхой бичнэ.

Даатгагчийн эрх бүхий албан тушаалтан томилох

- 18) Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны албан тушаал, овог, нэр, иргэний харьяалал, регистрийн дугаар, утасны дугаарыг хүснэгтийн дагуу бичнэ.

Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх

- 19) Эрхлэх албан журмын даатгалын хэлбэрийн нэрийг бичнэ.
- 20) Эрх бүхий этгээдийн гаргасан сонгосон албан журмын даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх шийдвэрийн нэр, шийдвэр гаргасан огноо, шийдвэрийн дугаарыг бичнэ.

3.2.1.даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Даатгагчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл /хувьцаа эзэмшигчийн шийдвэр/-ийн хүчин төгөлдөр эх хувь.
2. Дүрмийн санд өөрчлөлт орохтой холбоотойгоор шинэчлэн боловсруулсан компанийн дүрмийн төсөл;
3. Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөн бол дүрмийн санд оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь зээлийн хөрөнгөөр бүрдээгүй, мөн хууль бус үйл ажиллагаанаас орсон орлого биш гэдгийг батлахуйц баримт, бичгийг бүрдүүлнэ. Тухайлбал, хуримтлагдсан ашгаас дүрмийн санг бүрдүүлж байгаа нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг хуваарилах шийдвэр, хөрөнгийн орлогын албан татварын баримт, хөрөнгө худалдан борлуулсны орлогоор дүрмийн санг бүрдүүлэх нөхцөлд тухайн хөрөнгө хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хөрөнгө мөн эсэхийг нотлох баримт бичиг, хөрөнгө худалдах худалдан авах гэрээ, төлбөр хийгдсэнийг нотлох баримт бичиг, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар төлсөн баримт, хувьцаа эзэмшигч нь хувь хүн бөгөөд хувийн харилцах, хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгөөсөө дүрмийн санг бүрдүүлэх нөхцөлд харилцах хадгаламжийн дансны хуулга гэх мэт.
4. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд СЗХ04005 маягтын дагуу шинэ хувьцаа эзэмшигч тодорхойлолт гаргана. Тодорхойлолтод хувьцаа эзэмшигчийн иргэний цахим үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ), эрхэлж буй ажил, албан тушаалыг нотлох баримтыг хавсаргана. (тухайлбал нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт...)
5. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааварт заасан хувь хүн, хуулийн этгээд бүрийн бөглөсөн асуулгын хуудсыг бөглөнө.

3.2.2.даатгалын байгууллагын салбар, төлөөлөгчийн газар нээх зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Салбар, төлөөлөгчийн газар нээх тухай удирдлагын шийдвэрийн эх хувь эсхүл шийдвэрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар /хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, хувьцаа эзэмшигчийн шийдвэр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тогтоол гэх мэт/
2. Ажлын байрыг худалдан авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, түрээслэсэн бол түрээсийн гэрээний хуулбар.
3. СЗХ04006 маягтын дагуу гаргасан салбар, төлөөлөгчийн газрын удирдлага, мэргэжлийн боловсон хүчин бүрийн бөглөсөн тодорхойлолт.
4. Салбар, төлөөлөгчийн газрын удирдлага болон мэргэжлийн /даатгалын борлуулалтын ажилтан, даатгалын менежер, даатгалын нөхөн төлбөрийн ахлах ажилтан/ боловсон хүчний иргэний цахим үнэмлэхний хуулбар, мэргэжлийн /даатгал, санхүү, эдийн засаг болон бусад/ дипломын хуулбар, мэргэшлийн үнэмлэх, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, өмнө нь даатгалын байгууллагад ажиллаж байсан бол тус байгууллагын гаргасан тодорхойлолт, нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
5. Салбар нээхтэй холбоотойгоор өөрчлөлт оруулсан 3-аас доошгүй жилийн бизнес төлөвлөгөө.
6. Салбар, төлөөлөгчийн газрын эрхлэх үйл ажиллагааны чиглэл, дотоод үйл ажиллагаанд баримтлах зарчим, дүрмийг тодорхойлсон дотоод үйл ажиллагааны журмын төсөл.
7. Салбарын удирдлага эсхүл боловсон хүчин нь Хороо, холбогдох мэргэжлийн холбоодтой хамтран зохион байгуулсан даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцсэнийг нотлох баримт.

дугаартай баримт бичгүүдээс гадна эрхлэх даатгалын хэлбэрээс хамааран эд хөрөнгөд учирсан бодит хохирлыг тогтоох бол салбарын 1-ээс доошгүй ажилтны Хөрөнгийн үнэлгээний тусгай зөвшөөрлийн гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хавсаргана.

9. Даатгалын компани салбар нээх зөвшөөрөл хүссэн тохиолдолд тухайн салбарын арилжааны банкин дахь дансны хуулга.
10. Даатгалын компанийн салбар нь Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тохиолдолд салбарын шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын шуурхай албаны бүтэц бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга.
11. Шуурхай албаны эсхүл шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр гэрээ хийсэн байгууллагын дуудлагын зориулалтын автомашины гэрчилгээний хуулбар.
12. Даатгалын компани нь тухайн салбарын шуурхай албаны үйл ажиллагааг гүйцэтгүүлэхээр бусад хуулийн этгээдтэй байгуулсан гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
13. Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааврын дагуу гадаад улсад нээх салбар, төлөөлөгчийн газрын удирдах ажилтны бөглөсөн асуулгын хуудас.
14. Гадаад улсад төлөөлөгчийн газар нээх тохиолдолд Төлөөлөгчийн газар нээх үндэслэл, зорилго, үйл ажиллагааны чиглэлийн талаарх дэлгэрэнгүй тайлбар.

3.2.3.даатгалын байгууллагын оноосон нэр өөрчлөх зөвшөөрлийн өргөдөлд хавсаргах баримт бичиг, түүнд тавигдах шаардлага

1. Хуулийн этгээдийн оноосон нэрийг өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, эрх бүхий этгээдийн шийдвэрийн эх хувь, нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
2. Улсын бүртгэлийн албанаас авсан шинэ оноосон нэрийн баталгаажуулалт.
3. Хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдөж байгаатай холбогдуулан шинэчилсэн компанийн дүрмийн төсөл.

3.2.4.даатгагчийн эрх бүхий албан тушаалтан томилох зөвшөөрөл хүссэн өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Эрх бүхий албан тушаалтныг томилох тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэр: Компанийн дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд тухайн эрх бүхий албан тушаалтныг томилох тухай Хувьцаа эзэмшигчдийн хурал эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хуулбар, хүчин төгөлдөр шийдвэрийн эх хувь;
2. СЗХ04006 маягтын дагуу гаргасан шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт.
3. Шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны иргэний цахим үнэмлэх, мэргэжлийн диплом, эрхэлж байсан болон эрхэлж буй ажил, албан тушаалыг нотлох баримт бичиг (нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт...)-ийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
4. Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар"-т заасны дагуу шинэ эрх бүхий албан тушаалтны бөглөсөн асуулгын хуудас

1. Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай удирдлагын шийдвэр /Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол гэх мэт/-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
2. Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэх тухай удирдлагын шийдвэр /Хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоол гэх мэт/-ийн эх хувь эсхүл нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
3. Албан журмын даатгалын үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдуулан даатгагчийн бизнес төлөвлөгөөнд оруулсан өөрчлөлт
4. Албан журмын даатгалын үйл ажиллагааны мэдээллийн сангийн бүртгэл хөтлөх болон тухайн даатгалын чиглэлийн мэргэжлийн боловсон хүчний СЗХ04006 маягтын дагуу гаргасан тодорхойлолт.
5. Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын тохиолдлыг шалгах шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулга. Хэрвээ даатгалын компани нь шуурхай албаны үйл ажиллагааг Албан журмын даатгагчдын холбоо болон хууль тогтоомжид заасан бусад байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх тохиолдолд гэрээ хийсэн байгууллагын шуурхай албаны бүтэц, бүрэлдэхүүн, зохион байгуулалтын талаарх танилцуулгыг хавсаргана.
6. Шуурхай албаны үйл ажиллагааг бусад байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлэх тохиолдолд тухайн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.
7. Албан журмын даатгалын хэлбэрээс хамааран хууль тогтоомжид заасан бусад шаардлагатай баримт бичиг.

Дөрөв. Бүртгэлийн өргөдлийн маягтыг бөглөх, баримт бичгийг бүрдүүлэх

4.1. Бүртгэлийн өргөдлийн СЗХ04004 маягтыг бөглөх

- 1) Өргөдөл гаргасан огноо: Он, сар, өдөр гэсэн дарааллаар тоогоор бичнэ.
- 2) Өргөдөл/хүсэлт гаргагч даатгалын байгууллагын нэр: Даатгалын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.
- 3) Регистрийн дугаар: Даатгалын байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ..
- 4) Бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгох: Маягтад дурдсан 4 төрлөөс бүртгүүлэхээр хүсэлт гаргаж буй төрлийг сонгох бөгөөд сонгосон төрөлтэй холбогдуулан дараах байдлаар мэдээллийг бөглөнө.
 - “Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 5, 6 дугаар хэсгийг бөглөнө.
 - “Даатгалын мэргэжлийн оролцогчийн дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчийн бүрэлдэхүүний өөрчлөлт” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 7, 8 дугаар хэсгийг бөглөнө.
 - “Даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлт” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 9 дүгээр хэсгийг бөглөнө.
 - “Хаягийн өөрчлөлт” төрлийг сонгосон нөхцөлд маягтын 10 дугаар хэсгийг бөглөнө.

Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн бүртгүүлэх

- 5) Бүртгүүлэх хүсэлт гаргаж буй даатгалын хэлбэр, түүнд хамаарах бүтээгдэхүүний нэрийг бичнэ.

Даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийг бүртгүүлэх

-Хувьцаа эзэмшигч: Хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний цахим үнэмлэх дэх овог нэр, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх оноосон нэрийг бичнэ.

-Регистрийн дугаар: Хувьцаа эзэмшигч иргэн бол иргэний цахим үнэмлэх дэх регистрийн дугаар, хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.

-Одоогийн ХНХ хэмжээ: Хороонд бүртгүүлсэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигч тус бүрээр төгрөгөөр илэрхийлж бичнэ.

-Нэмэгдсэн: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж байгаа тохиолдолд нэмэгдүүлж буй дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

-Хорогдсон: Одоогийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээгээ бууруулж байгаа тохиолдолд бууруулж буй дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

-Өөрчлөлтийн дараа ХНХ хэмжээ: Одоогийн ХНХ хэмжээн дээр нэмэгдүүлж буй дүнг нэмээд, бууруулж буй дүнг хасаад гарсан дүнг төгрөгөөр илэрхийлж бичнэ.

-Өөрчлөлтийн дараа ХНХ-д эзлэх хувь: Даатгалын мэргэжлийн оролцогчийн дүрмийн сангийн хэмжээ, бүтэц, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орсны дараагаар дүрмийн санд хувьцаа эзэмшигч тус бүрийн эзлэх хувийг гаргаж бичнэ. (Нийт дүрмийн санг 100% гэж үзнэ)

Даатгалын зуучлагчийн, хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх

- 7) Даатгалын мэргэжлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтныг бүртгүүлэхдээ дараах мэдээллийг бөглөнө:
- Албан тушаал: Тухайн байгууллагад эрхлэх албан тушаалыг бичнэ.
 - Овог, нэр, регистрийн дугаар: Тухайн албан тушаалтны иргэний цахим үнэмлэх дэх овог, нэр, регистрийн дугаарыг бичнэ.
 - Утасны дугаар: Тухайн албан тушаалтны гэрийн болон гар утасны дугаарыг бичнэ.

Хаяг, байршлын өөрчлөлтийг бүртгүүлэх

- 8) -Нэгжийн нэр: Даатгалын байгууллагын төв компани, салбар, төлөөлөгчийн газар аль нь болохыг тодорхой зааж бичнэ. Тухайлбал: Төв компани, Сэлэнгэ аймаг дахь салбар, Баянхонгор аймаг дахь төлөөлөгчийн газар гэх мэт...
- Хаяг: Хуучин хаяг байршил хэсэгт хуучин ашиглаж байсан Хороонд бүртгэлтэй хаягийг бичнэ. Шинэ хаяг байршил хэсэгт шинээр ажлын байрыг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээн дэх хаяг, түрээслэсэн бол түрээсийн гэрээн дэх хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж, байр, тоот гэсэн дарааллаар бүрэн гүйцэт бичнэ.
- Холбоо барих утас: Тухайн нэгжийн ашиглаж буй суурин утас болон холбогдох албан тушаалтны утсыг бичнэ.

4.2. Бүртгэлийн өргөдлийн СЗХ04004 маягтын дагуу гаргасан өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

4.2.1. даатгалын хэлбэр, бүтээгдэхүүн бүртгүүлэх өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Компанийн дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд тухайн даатгалын хэлбэрээр үйл ажиллагаа эрхлэх тухай Хувьцаа эзэмшигчдийн хурал эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн тэмдэглэл, хүчин төгөлдөр шийдвэрийн эх хувь;
2. Даатгалын байгууллагын боловсон хүчний мэргэжлийн диплом, холбогдох сургалтад хамрагдсаныг нотлох гэрчилгээ, сертификат болон сургалтын хөтөлбөрт тухайн чиглэлээр хичээл орсон эсэхийг нотлох баримт бичиг, тодорхойлолтын нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, СЗХ04006 маягтын дагуу гаргасан тодорхойлолт.

4. Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнийг борлуулах шаардлага, хэрэгцээ, зах зээлийн багтаамж, ашигт ажиллагаа, борлуулалтын суваг, давхар даатгуулах эсэх зэрэг мэдээллийг багтаасан судалгаа, танилцуулга.
5. Даатгалын гэрээ, баталгааны загвар: Иргэний хуулийн 431.4 дэх хэсэгт заасан нөхцөлийг тусгасан, Даатгалын тухай хууль болон даатгалын багц дүрмээр тавигдсан шаардлагыг хангасан даатгалын бүтээгдэхүүний гэрээний болон баталгааны загвар;
6. Даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний журам: Тухайн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүнтэй холбоотойгоор даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөр олгохтой холбоотой харилцааг нарийвчлан зохицуулсан журам, заавар;
7. Даатгалын хэлбэрт хамаарах бүтээгдэхүүн тус бүрийн хураамжийн хувь хэмжээ, нөөц сангийн тооцоолол, танилцуулга: Даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн хувьд даатгалын хураамжийн хэмжээг тооцоолохдоо ашигласан тоон мэдээлэл, аргачлал, эрсдэл тус бүрийн түвшин, хувь хэмжээ, түүнийг тооцоолсон аргачлал, цэвэр хураамжийн хувь, нийт хураамжийн хувийн талаарх мэдээллийг агуулсан актуарын тайлан, танилцуулга.

4.2.2.даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Даатгалын мэргэжлийн оролцогчийн дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл /хувьцаа эзэмшигчийн шийдвэр/-ийн хүчин төгөлдөр эх хувь.
2. Дүрмийн санд өөрчлөлт орохтой холбоотойгоор шинэчлэн боловсруулсан компанийн дүрмийн төсөл;
3. Дүрмийн сангийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөн бол дүрмийн санд оруулсан мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь зээлийн хөрөнгөөр бүрдээгүй, мөн хууль бус үйл ажиллагаанаас орсон орлого биш гэдгийг батлахуйц баримт, бичгийг бүрдүүлнэ. Тухайлбал, хуримтлагдсан ашгаас дүрмийн санг бүрдүүлж байгаа нөхцөлд хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг хуваарилах шийдвэр, хөрөнгийн орлогын албан татварын баримт, хөрөнгө худалдан борлуулсны орлогоор дүрмийн санг бүрдүүлэх нөхцөлд тухайн хөрөнгө хувьцаа эзэмшигчийн эзэмшлийн хөрөнгө мөн эсэхийг нотлох баримт бичиг, хөрөнгө худалдах худалдан авах гэрээ, төлбөр хийгдсэнийг нотлох баримт бичиг, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар төлсөн баримт, хувьцаа эзэмшигч нь хувь хүн бөгөөд хувийн харилцах, хадгаламжийн дансан дахь мөнгөн хөрөнгөөсөө дүрмийн санг бүрдүүлэх нөхцөлд харилцах хадгаламжийн дансны хуулга гэх мэт.
4. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд СЗХ04005 маягтын дагуу шинэ хувьцаа эзэмшигч тодорхойлолт гаргана. Тодорхойлолтод хувьцаа эзэмшигчийн иргэний цахим үнэмлэх (хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээ), эрхэлж буй ажил, албан тушаалыг нотлох баримтыг хавсаргана. (тухайлбал нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт...)
5. Хувьцаа эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох зааварт заасан хувь хүн, хуулийн этгээд бүрийн бөглөсөн асуулгын хуудсыг бөглөнө.

4.2.3.даатгалын зуучлагч, хохирол үнэлэгчийн эрх бүхий албан тушаалтны өөрчлөлтийг бүртгүүлэх өргөдөлд хавсаргах баримт бичиг, тавигдах шаардлага

1. Эрх бүхий албан тушаалтныг томилох тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр эсхүл эрх бүхий этгээдийн шийдвэр: Компанийн дүрэмд заасан эрх хэмжээний хүрээнд тухайн эрх бүхий албан тушаалтныг томилох тухай Хувьцаа эзэмшигчдийн хурал эсвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлын тэмдэглэлийн хуулбар, хүчин төгөлдөр шийдвэрийн эх хувь;
2. СЗХ04006 маягтын дагуу гаргасан шинээр томилогдож буй эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт.

(нийгмийн даатгалын дэвтэр, албан байгууллагын тодорхойлолт гэх мэт...)-ийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар.

4. Хорооноос баталсан даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн Тохиромжтой этгээдийг тодорхойлох заавар"-т заасны дагуу шинэ эрх бүхий албан тушаалтны бөглөсөн асуулгын хуудас

4.2.4.даатгалын байгууллага хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэхээр өргөдөл гаргахдаа ажлын байрыг худалдаж авсан бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, түрээслэсэн бол түрээсийн гэрээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг өргөдөлд хавсаргана.

Тав. Тодорхойлолт бөглөх

5.1. Хувьцаа эзэмшигчийн тодорхойлолт СЗХ04005 маягтыг бөглөх

- 1) Хороонд өргөдөл гаргаж буй хуулийн этгээдийн оноосон нэрийг бичнэ.
- 2) Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд, иргэн аль нь болохыг сонгоно. Хуулийн этгээд бол 3-15, 24 дүгээр мөрүүдийг бөглөнө. Иргэн бол 16-24 дүгээр мөрүүдийг бөглөнө.

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн мэдээлэл

- 3) Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн оноосон нэрийг бичнэ:
Монгол – хуулийн этгээдийн оноосон нэрийг кирилл үсгээр;
Англи – хуулийн этгээдийн нэрийг латин үсгээр галиглан бичнэ.
- 4) Хуулийн этгээдийн үүсгэн байгуулсан хурлын огноог он, сар, өдөр гэсэн дарааллаар бичнэ.
- 5) Хуулийн этгээдийн хэлбэр: ХК-хувьцаат компани, ХХК- Хязгаарлагдмал хариуцлагатай компанийн аль нь болохыг сонгоно.
- 6) Хөрөнгө оруулалтын хэлбэрээс тохирох нүдийг сонгож, гадаадын хөрөнгө оруулалттай бол нийт хувьцааны хэдэн хувийг гадаадын хөрөнгө оруулагч
*Дотоодын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт хувьцааг /100 хувь/ Монгол улсын иргэн , Монгол улсад бүртгэлтэй хуулийн этгээд эзэмшдэг,
Гадаадын хөрөнгө оруулалттай компани гэдэгт нийт гаргасан хувьцааны 25 буюу түүнээс дээш хувийг гадаадын хөрөнгө оруулагч эзэмшиж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулагч тус бүрийн оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ 100 мянган ам.доллар буюу түүнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөс дээш байх аж ахуй нэгжийг тус тус ойлгоно.*
- 7) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх улсын бүртгэлийн дугаарыг бичнэ.
- 8) Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээн дэх регистрийн дугаарыг бичнэ.
- 9) Хуулийн этгээдийн эрхэлж буй үйл ажиллагааны чиглэлийг бичнэ.
- 10) Өргөдөл гаргагч хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.
- 11) Хаяг байршил: Хуулийн этгээдийн хаягийг хүснэгтийн дагуу дэлгэрэнгүй бичнэ.
- 12) Холбоо барих утас: Хуулийн этгээдийн холбоо барих суурин, гар утас, факсны дугаарыг бичнэ.
- 13) Цахим хуудас: Хуулийн этгээдийн албан ёсны цахим хуудсыг бичнэ.
Цахим шуудангийн хаяг: Хуулийн этгээдийн цахим шуудангийн хаягийг бичнэ
- 14) Хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, нэр, регистрийн дугаар, холбоо барих утасны дугаарыг бичнэ.

Хувьцаа эзэмшигч иргэний мэдээлэл

- 15) Хувьцаа эзэмшигч иргэний овог буюу иргэний цахим үнэмлэх дээрх эцэг/эх/-ийн нэрийг бичнэ.
- 16) Хувьцаа эзэмшигч иргэний нэрийг бичнэ.
- 17) Иргэний регистрийн дугаарыг бичнэ.

- 19) Тодорхойлолт гаргаж буй өдрийн байдлаарх эрхэлж байгаа ажил, ажиллаж буй газар, албан тушаалын талаар бичнэ.
- 20) Ажил эрхэлдэг бол ажлын газрын хаягийг улс, аймаг/хот, сум/дүүрэг, баг/хороо, гудамж/байр, тоот гэсэн дарааллаар бичнэ.
- 21) Хувьцаа эзэмшигч нь мэргэжил эзэмшсэн бол эзэмшсэн мэргэжлийн нэрийг бичнэ.
- 22) Өргөдөл гаргагч иргэнтэй холбоо барих утасны дугаарыг бичнэ.
- 23) Өргөдөл гаргагч хуулийн этгээдэд оруулах хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг төгрөгөөр илэрхийлэн бичнэ.
- 24) Хувь нийлүүлсэн хөрөнгийн эх үүсвэрийн нэрийг, тухайн эх үүсвэрийн мөнгөн дүнг төгрөгөөр илэрхийлэн бичнэ. /Компанийн ногдол ашиг, тээврийн хэрэгсэл, үл хөдлөх хөрөнгө борлуулсны орлого, бизнес, хадгаламж, түрээсийн орлого, менежментийн урамшуулал гэх мэт/

5.2.Эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний тодорхойлолт СЗХ04006 маягтыг бөглөх

- 1) Ерөнхий мэдээлэл хэсэгт Компанийн тухай хуулийн 84.1-д заасан эрх бүхий албан тушаалтан болон боловсон хүчин нь өөрийн мэдээллийг хүснэгтийн дагуу оруулна.
-Эрхлэх албан тушаал мөрөнд даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн хуулийн этгээдэд эрхлэх албан тушаалын нэрийг бичнэ. Дараагийн мөрөнд тухайн албан тушаалд томилогдсон огноо, шийдвэрийн нэр/ТУЗ-ын тогтоол, гүйцэтгэх захирлын тушаал гэх мэт/, шийдвэрийн дугаарыг бичнэ.
-Өөр байгууллагад давхар ажил эрхэлдэггүй тохиолдолд “Одоо эрхэлж байгаа ажил, Албан тушаал, Ажлын хаяг, Ажлын цахим хаяг” гэсэн удаах мөрүүдийг бөглөх шаардлагагүй. Өөр байгууллагад давхар ажил эрхэлж байгаа тохиолдолд дээрх мөрүүдийг бөглөнө.
-Маягтад сүүлийн 3 сарын дотор авахуулсан 3*4 хэмжээтэй цээж зургийг оруулна.
- 2) Боловсролын талаарх мэдээллийг хүснэгтүүдийн дагуу оруулна. Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан боловсрол эзэмшсэн их дээд сургуулиудын нэрс, эзэмшсэн мэргэжил, тухайн сургуульд элссэн, төгссөн он, диплом, гэрчилгээний дугаарыг бичнэ. Мөн санхүүгийн болон даатгалын чиглэлээр мэргэшил олгох сургалтад хамрагдсан бол тухайн мэргэшил олгосон сургалтын байгууллагын нэр, эзэмшсэн мэргэжил хэсэгт мэргэшлийн нэр, тухайн сургалтад элсэн орсон, төгссөн огноо, гэрчилгээ, мэргэшлийн үнэмлэхний дугаарыг бичнэ.
- 3) Ажлын туршлагын талаарх мэдээллийг хүснэгтүүдийн дагуу оруулна. Хаана ажиллаж байсан хэсэгт ажиллаж байсан байгууллагын нэр, тухайн байгууллагад эрхэлж байсан албан тушаал, ажилд орсон огноо, ажлаас гарсан огноо, ажлаас гарсан шалтгааныг товч тодорхой бичнэ.
- 4) Холбогдох этгээд гэдэгт Компанийн тухай хуулийн 89.2-т заасан нэгдмэл сонирхолтой этгээдийг ойлгоно. Холбогдох этгээд нь эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний Компанийн тухай хуулийн 89.2-т заасан этгээдийн аль нь болохыг тодорхойлж “таны хэн болох” хэсэгт бичнэ. Холбогдох этгээд нь иргэн бол түүний овог, нэр, регистрийн дугаар, эрхэлж буй ажил эсхүл ажиллаж буй байгууллагын нэр, албан тушаалыг бичнэ. Холбогдох этгээд нь хуулийн этгээд бол хуулийн этгээдийн оноосон нэр, регистрийн дугаарыг бичнэ.

Зургаа. Бусад

6.1.Энэ зааврын дагуу даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн маягтыг бөглөөгүй, баримт бичгийг бүрдүүлээгүй тохиолдолд даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэлийн баримт бичгийг бүрэн гүйцэд бүрдүүлээгүй гэж үзэх үндэслэл болно.

Бизнес төлөвлөгөө боловсруулах зөвлөмж

Бизнес төлөвлөгөө гэж нь компанийн стратеги, зорилтыг тодорхойлж, компанийн үйл ажиллагааг эрхлэхэд түүний бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа, удирдлагын ур чадвар, санхүү, төлбөрийн чадварын үзүүлэлт, үр ашгийг жил тутам сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхой цаг хугацаагаар төлөвлөн боловсруулсан баримтыг хэлнэ.

Бизнес төлөвлөгөөг 3-аас доошгүй жилийн хугацаатай боловсруулах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэрлэсэн байна. Бизнес төлөвлөгөө нь эмх цэгцтэй, ойлгомжтой, бүлэг хэсгүүд нь уялдаа бүхий мэдээлэл нь цаг хугацаандаа, үнэн бодитой, үр дүн нь хэмжигдэхүйц байвал зохино.

1. Бизнес төлөвлөгөөний нүүр хуудсанд дараах зүйлсийг тусган харуулна:
 - Хуулийн этгээдийн нэр, хаяг
 - Бизнес төлөвлөгөөний нэр
 - Хувилбарын дугаар
 - Боловсруулсан огноо
 - Баталсан шийдвэрийн огноо, дугаар
 - Зохиогчийн нэр, хаяг
 - Зохиогчийн тэмдэглэл
 - Хуулийн этгээдийн удирдлагын нэр, хаяг
2. Компани нь бизнес төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагааны онцлогтой уялдуулан дараахь асуудлуудыг тусгасан байна. Үүнд:
 - 2.1. Компанийн үйл ажиллагааны зорилго, зорилт
 - 2.2. Компанийн үйл ажиллагаа эрхлэхэд ашигтай байх макро болон микро түвшин дэх боломжит нөхцөлүүд
 - 2.3. Компанийн тайлан тэнцэл, мөнгөн хөрөнгийн урсгал, орлого зарлагын 3-аас доошгүй жилийн төсөөлөл
 - 2.4. Үйл ажиллагаатай холбогдон гарах эрсдэлийг тодорхойлж, түүнийг удирдахад авах арга хэмжээ
 - 2.5. Компанийн засаглалыг боловсронгуй болгох, сайжруулах төлөвлөгөө
3. Бизнес төлөвлөгөө нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

I. ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУРААНГУЙ

Энэ бүлэгт тухайн бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь хэрэгжүүлэх гэж буй бизнес төлөвлөгөөний эрхэм зорилго, зорилт, амжилтын үндэс, учирч болох эрсдэл болон санхүүгийн бусад үзүүлэлтүүдийн тухай товч мэдээллийг багтаана.

Эрхэм зорилго гэдэг нь үйлчлүүлэгч, даатгуулагчдын ямар хэрэгцээг, ямар арга замаар хангах тухай тодорхойлолт юм.

II. БИЗНЕСИЙН ТАНИЛЦУУЛГА

Бизнесийн танилцуулга гэдэг нь тухайн компанийн нэр, хаяг, хариуцлагын тогтолцоо, зах зээлийн нөхцөл төлөв байдал, эрхлэх гэж буй даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа, гаргаж буй үйлчилгээ түүнчлэн удирдлага боловсон хүчний хангалт, санхүүгийн чадавхи ба байдал бизнес төлөвлөгөө бичих болсон шалтгаан, зорилго зорилтууд түүнийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэр, үйл ажиллагааны үр ашиг, борлуулалтын орлого, ашиг зэргийг тусган харуулсан хураангуй тодорхойлолт юм.

Бизнесийн танилцуулга нь дараах үндсэн хэсгүүдээс бүрдэнэ:

1. Компанийн түүх

1.1. Компанийн түүх: Энэ хэсэгт танай компани анх хэдэн онд байгуулагдсан, ямар бизнес эрхэлж байсан, компанийн түүх, ололт амжилтын талаар дурдахаас гадна одоогийн явуулж буй үйл ажиллагаа, бизнесийн чиглэл, бүтээгдэхүүн үйлчилгээ, бүтэц бүрэлдэхүүний талаар бичнэ. Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй.

1.2. Одоогийн явуулж буй үйл ажиллагаа: Хуулийн этгээд бизнесийн аль салбарт ямар чиглэлээр бүтээгдэхүүн үйлчилгээ эрхэлдэг, одоогийн бизнесийн орчин, эзэмшиж буй тоног төхөөрөмж, барилга байгууламж, хөрөнгө оруулалтын хэмжээ, бүтээгдэхүүн үйлчилгээний тоо хэмжээ, нийлүүлэгч, хамтран ажилладаг байгууллага, харилцагчдын талаарх мэдээллийг бичнэ. Өмнө нь үйл ажиллагаа явуулж байгаагүй бол бичих шаардлагагүй.

1.3 Хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцаа эзэмшилт: Хуулийн этгээдийг хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгийн талаар дэлгэрэнгүй бичнэ.

1.4 Бүтэц зохион байгуулалт, удирдлага, хүний нөөц: Энэ хэсэгт тухайн байгууллагын боловсон хүчний бүтэц, зохион байгуулалт, удирдлагын багийн танилцуулга, тэдний өмнө хийж байсан ажил, ажлын туршлага, одоогийн хариуцан ажилладаг ажлын талаар танилцуулна. Тухайн байгууллагын зохион байгуулалтын бүтцийг схемчлэн зурж болно. Боловсон хүчний талаар одоо компанид нийт хэдэн хүн ажиллах, тэднээс хэд нь үндсэн ажилчин, хэд нь гэрээт ажилчин байх, тэдгээрийн цалин хөлс, ямар ямар чиглэлийн ажил хариуцдаг, ажилчид дотроо газар, хэлтэс, салбар зэрэгт хуваагддаг эсэх талаар бичнэ. Цаашид ажилчдын тоог нэмэгдүүлэх эсэх талаар тодруулна.

2. Зах зээлийн нөхцөл төлөв байдал

Зах зээлийн байдал, хэрэглэгчид, зах зээлд гарч байгаа ерөнхий чиг хандлага, тухайн бизнесийн хууль эрх зүйн орчин, тухайн салбар дахь өрсөлдөгчдийн талаар мэдээллүүдийг багтаана.

2.1 Зах зээл, хэрэглэгч, зах зээлийн ерөнхий чиг хандлага: Энэ хэсэгт зах зээлийн хэмжээ, хэрэглэгчдийн тоо хэмжээ, тухайн хуулийн этгээдийн зах зээлд эзлэх хувь, зах зээлийн өсөлт, ирээдүйн зах зээлийн байдал, зах зээлийн тогтвортой байдал, зах зээлд гарч байгаа ерөнхий чиг хандлагуудыг бичих бөгөөд технологийн хөгжил, байгалийн хүчин зүйлс, хүн амын суурьшилт зэргийг тодруулна.

2.2 Бизнесийн хууль эрх зүйн орчин: Тухайн бизнесийг эрхлэхтэй холбоотой хуулиудыг судалсан эсэх, шаардагдах бичиг баримтыг бүрдүүлж баталгаажуулсан эсэх, хууль эрх зүйн орчинд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах арга замыг тодорхой бичнэ.

болон сул талуудын талаар дурдана. Компанийн дотоод, гадаад хүчин зүйлсийг судалсан SWOT шинжилгээг хийсэн байвал зохино.

Өрсөлдөгчийн нэр	Байршил	Бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөл	Багцын хэмжээ	Бүтээгдэхүүн үйлчилгээний үнэ, хүүгийн хэмжээ	Зах зээлд эзлэх байр суурь
Өрсөлдөгч 1					
Өрсөлдөгч 2					
Өөрийнх					

2.4 Бизнес төлөвлөгөө бичих болсон үндэслэлүүд: Яагаад шинээр үйл ажиллагаа эрхлэх болсон шалтгааныг бичиж, зах зээл, өөрийн хүчин чадлын хэмжээг харгалзан тухайн бизнесийг өргөжүүлэх нөөц, боломжийг тодруулна.

3. Төлөвлөсөн бизнесийн үйл ажиллагаа:

3.1 Бүтээгдэхүүн үйл ажиллагааны төлөвлөгөө: Эрхлэх гэж буй даатгалын хэлбэрийн дэлгэрэнгүй болон үйл ажиллагаа эрхлэн явуулснаар тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг ямар хэмжээгээр хүргэх, харилцагч, үйлчлүүлэгчдийн цар хүрээг тодорхойлж, тооцооллыг хийнэ.

3.2 Маркетингийн төлөвлөгөө: Өмнөх бүлэгт хийсэн зах зээл, хэрэглэгчдийн судалгааг үндэслэн боловсруулна. Үүнд зах зээлээ сонгох, бүтээгдэхүүн үйлчилгээг идэвхжүүлэх үйл ажиллагаа орно. Маркетингийн төлөвлөгөө нь маркетингийн иж бүрдлээс бүрдэнэ. Үүнд: Бүтээгдэхүүн (үйлчилгээ), Үнэ (үнийг хэрхэн тогтоох), Байрлал (суваг, хуваарилалт), Идэвхжүүлэлт (зар сурталчилгаа) зэргийг хэрхэн шийдвэрлэснээ тодорхойлно.

3.3 Менежментийн төлөвлөгөө: Байгууллагын удирдлага, бүтэц, зохион байгуулалт, удирдах ажилтан бүрийн хариуцлага, ажилчдын нэрс, цалингийн зардлыг тодорхой бичиж, боловсон хүчнийг бэлтгэх, чадваржуулах шаардлага, тэдгээрт хийх сургалтын талаар тодруулна.

3.4 Санхүүгийн төлөвлөгөө: Санхүүгийн төлөвлөгөөнд бизнесийн үйл ажиллагаа явуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэр, орлого, зардал, ашиг, алдагдлыг тооцож, түүнийг хэрхэн удирдах талаар тусгана. /Даатгалын компани бол даатгалын үнэлгээ, даатгалын хураамж, нөөц сан, нөхөн төлбөр, давхар даатгалын хураамж, даатгалын бус үйл ажиллагааны орлого гэх мэт үзүүлэлтүүдийн тооцооллыг тусгана./

Орлогыг тооцохдоо тухайн орлогыг бүрдүүлэх эх үүсвэр бүрээр тооцож нэгтгэн гаргана.

Зардлыг тооцохдоо бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбогдон гарах, удирдлага зохион байгуулалттай холбогдон гарах, албан татвар хураамж төлөх, хөрөнгө оруулалттай холбогдон гарах, бусад зардал гэх мэтчилэн зардлын зүйл анги бүрээр тооцож, нэгтгэн гаргана.

Мөнгөн урсгалыг тооцохдоо сар бүрийн орж, гарах мөнгөн урсгалыг тооцож, жилээр нэгтгэн гаргана.

Санхүүгийн тайлан баланс зэрэг тоон үзүүлэлтийг бизнес төлөвлөгөөнд тусгахдаа өмнөх онуудын гүйцэтгэлийг ирэх жилийн төлөвлөгөөтэй зэрэгцүүлсэн байдлаар гаргана.

оруулалтыг хаанаас авахаар төлөвлөөд байгаа /банкны зээл, гадаадын хөрөнгө оруулалт, олон улсын байгууллагын тусламж хөрөнгө оруулалт, гадаадын банкнаас авах зээл, хувь нийлүүлэгчдийн хөрөнгө оруулалт/-талаар бичнэ. Хэрэв өглөг авлагатай бол энэ талаар жагсаалт үйлдэж, нарийвчлан тодруулсан байна.

3.6 Эрсдэлийн менежмент /бууруулах арга зам: Бизнес эрхлэхэд олон төрлийн эрсдэл учирч болох бөгөөд техник, санхүү, байгалийн гамшиг, хууль эрх зүй, улс төрийн эрсдэлийг зайлшгүй тооцож өөрийн бизнесийн онцлогт уялдуулан бичнэ. Мөн таны бизнест ямар төрлийн эрсдэл учрах магадлал илүү эсэхийг тодорхойлж, эрсдлийг доод хэмжээнд байлгах, түүнээс сэргийлэх, бууруулахын тулд та ямар арга хэмжээ төлөвлөснөө бичих нь зүйтэй.

Дотоод үйл ажиллагааны журам боловсруулах зөвлөмж

Дотоод үйл ажиллагааны журам нь дараах зарчимд тулгуурлана:

- байгууллагын стратеги, зорилттой уялдсан байх;
- холбогдох хууль тогтоомж, журам, заавар, олон улсын конвенцийг удирдлага болгосон байх;
- санхүү, төлбөрийн чадвар, үр ашиг, удирдлагын ур чадвар, үйлчилгээний шуурхай, найдвартай ажиллагаа зэргийг харгалзан үзсэн байх;
- даатгуулагчийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхгүй байх.

Дотоод үйл ажиллагааны журамд дараах агуулгаар заалтуудыг заавал тусгасан байна:

1. Үйл ажиллагаанд мөрдөх журмын зорилгыг Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, Компанийн тухайн хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, Даатгалын багц дүрмийн хүрээнд даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагааны харилцааг зохицуулахад чиглүүлэх;
2. Үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой нийтлэг хэрэглэгддэг нэр томъёонуудын тайлбарыг оруулах;
3. Даатгалын болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд оролцогч талууд бие биендээ харилцан итгэж, үнэн бодит мэдээллээр хангах, хууль дээдлэх, шударга байх үндсэн зарчмуудыг тусгах;
4. Тухайн үйлчилгээг үзүүлж, үйл ажиллагааг явуулахад харилцагчаас бүрдүүлэх шаардлагатай баримтын жагсаалт гаргах;
5. Тухайн үйл ажиллагаа, үйлчилгээг хэрэгжүүлэхэд тавигдах нөхцөл, шаардлага, хүү, хураамж, шимтгэл, барьцаа эд хөрөнгө, батлан даалтын шалгуур үзүүлэлт, харилцагчдын холбогдох гэрээ, хувийн хэрэг зэргийг хэрхэн бүрдүүлж хадгалж, хамгаалах талаар тусгах;
6. Холбогдох хууль журамд заасны дагуу үүсгэн байгуулагч, хувь нийлүүлэгчдэд хуулиар тавьсан шаардлага, тухайн үйл ажиллагааг гүйцэтгэж байгаа ажилтнуудын эрх, үүргийн хэмжээ, хийж гүйцэтгэх, хянаж шийдвэрлэх, батлах хугацаа зэрэг ажилбаруудыг зааж өгөх;
7. Нягтлан бодох бүртгэлийг Хорооноос баталсан нягтлан бодох бүртгэлийн заавар, дансны жагсаалт, маягтын дагуу хөтөлж, санхүүгийн тайлан, мэдээг тогтоосон хугацаанд гаргах, Хороонд ирүүлж байх, үйл ажиллагаанд учирч болзошгүй аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлж, Даатгалын тухай хууль тогтоомж болон Хорооноос баталсан холбогдох журамд заасан шалгуур үзүүлэлтүүдийг ханган ажиллах;
8. Харилцагчдыг хуурамч мэдээллээр хангах, төөрөгдүүлэх, өөрийн болон гуравдагч этгээдийн ашиг сонирхолд нийцүүлэн мэдээллийг нуун дарагдуулах, өөрийн ажил үүрэгтэй холбоотой нийтэд тараагдаагүй мэдээллийг ашиглан ашиг олох, бусдад тараах, харилцагчаас төлбөл зохих үйлчилгээний хөлс болон зардлаас илүү хэмжээний төлбөр шаардахыг хориглох асуудлыг тодорхой заах;

ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН

Хуулийн этгээдийн нэр	
-----------------------	--

(он) / (сар) / (өдөр)
/төгрөгөөр/

ХӨРӨНГӨ	
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i>	
Бэлэн мөнгө	
Банкинд байгаа мөнгө	
Дансны авлага	
Бусад санхүүгийн хөрөнгө	
Урьдчилж төлсөн зардал	
Богино хугацаат хөрөнгө оруулалт	
Бусад эргэлтийн хөрөнгө	
<i>Эргэлтийн хөрөнгийн дүн</i>	
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ	
Үндсэн хөрөнгө	
Биет бус хөрөнгө	
Урт хугацаат хөрөнгө оруулалт	
Бусад эргэлтийн бус хөрөнгө	
<i>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</i>	
Нийт хөрөнгийн дүн	
ӨР ТӨЛБӨР	
<i>Богино хугацаат өр төлбөр</i>	
Дансны өглөг	
Урьдчилж орсон орлого	
Бусад богино хугацаат өр төлбөр	
<i>Урт хугацаат өр төлбөр</i>	
Урт хугацаат өр төлбөр	
Хойшлогдсон татварын өр төлбөр	
Бусад урт хугацаат өр төлбөр	
<i>Нийт өр төлбөр</i>	
ЭЗДИЙН ӨМЧ	
Өмч	
Нэмж төлөгдсөн капитал	
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	
Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	
Тусгай зориулалтын нөөцийн сангууд	
Эздийн өмчийн бусад хэсэг	
Хуримтлагдсан ашиг/алдагдал	
<i>Нийт хувь нийлүүлсэн хөрөнгө</i>	
Нийт өр төлбөр ба эздийн өмч	

.....
(Гүйцэтгэх удирдлагын гарын үсэг)

.....
(овог, нэр)